

МУИС-ИЙН 2019-2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ЗЭРЭГЦҮҮЛСЭН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ



Нэг. Сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн (Хавсралт-1)

МУИС-ийн 2019-2021 оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд зэрэгцүүлсэн шинжилгээ хийлээ. МУИС-ийн нийт хөрөнгийн дүн 2021 оны тайлангаар 122,193.0 сая төгрөг болж үүнээс 2019-2020 онд 4,750.5 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар, 2020-2021 онд 3,943.4 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар нэмэгдсэн байна. 2019-2021 онд эргэлтийн

хөрөнгийн хувийн жин нэмэгдэж эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь буурсан нь сүүлийн жилүүдэд үндсэн хөрөнгө (тэр дундаа барилга байгууламж)-ийн ажлаас илүүтэй үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн хувь хэмжээг нэмэгдүүлж тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалыг бий болгожээ.

Өөрийн хуримтлагдсан эх үүсвэрийн зохих хэсгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зарцуулсан ба мөнгөн хөрөнгийн нөөц жил тутам нэмэгдсээр байгаа нь тус сургуулийн төлбөрийн чадвар, санхүүгийн боломж хангалттайг илтгэн харуулж байна.


Хүснэгт 1. МУИС-ийн хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, үнийн дүнгийн өсөлт (2019-2021)

Хөрөнгө, эх үүсвэр	Хувийн жин			Өөрчлөлт			
				2019-2020 онд		2020-2021 онд	
	2019	2020	2021	сая.төг	хувиар	сая.төг	хувиар
1. Эргэлтийн хөрөнгө	38.6	42.7	43.6	6,581.5	15.0	2,777.2	5.5
Үүнээс: Мөнгөн хөрөнгө	35.1	33.9	37.5	193.9	0.5	5,779.4	14.4
Авлага	0.5	5.7	2.5	5,900.9	726.2	(3,620.7)	(53.9)
2. Эргэлтийн бус хөрөнгө	61.4	57.3	56.4	(1,831.0)	(2.6)	1,166.3	1.7
Нийт хөрөнгө	100.0	100.0	100.0	4,750.5	4.2	3,943.4	3.3
3. Богоино хугацаат өр, төлбөр	3.3	4.6	5.6	1,730.2	46.7	1,369.8	25.2
Үүнээс: УОО	2.6	4.5	5.5	2,361.3	80.1	1,372.5	25.9
Дансны өглөг	0.7	0.1	0.1	(631.1)	(83.4)	(19.5)	(15.5)
4. Эзэмшигчдийн өмч	96.7	95.4	94.4	3,020.3	2.7	2,573.6	2.28
Үүнээс: Хуримтлагдсан үр дүн тайлант оны	7.7	2.9	2.1	(6,120.1)	(70.4)	(856.9)	(25.0)
Өр төлбөр ба өмчийн дүн	100.0	100.0	100.0	4,750.5	4.2	3,943.4	3.3

Эргэлтийн хөрөнгө

2021 оны жилийн эцсээр нийт эргэлтийн хөрөнгө 53.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс 45.8 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 7.4 тэрбум төгрөг нь бараа материал болон авлага байна. Тайлант оны эцэст 45.8 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсны 22.6 тэрбум нь хугацаатай хадгаламж, 23.2 тэрбум төгрөг нь харилцах дансны үлдэгдэл байлаа. 2020 оны эргэлтийн хөрөнгийн өсөлтийн дийлэнх хувийг авлага эзэлж өмнөх оноос огцом өссөн нь сургалтын төрийн сангийн санхүүжилт хугацаандаа хийгдээгүйтэй холбоотой байна.

Зураг 1. Сүүлийн 10-н жилийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал:



Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр 2020 оны сургалтын төрийн сангийн авлага 2019 онтой нь харьцуулбал 96.6 хувиар өсч 6,264.9¹ сая төгрөгт хүрснийг 2021 оны жилийн эцсээр тус авлагыг 54.9 хувиар бууруулсан байна.

Хүснэгт 2. МУИС-ийн СТС-ийн авлага, авлагын өсөлт (2019-2021)

Авлага	Нийт дүн			Өөрчлөлт			
				2019-2021 онд		2020-2021 онд	
	2019	2020	2021	сая.төг	хувиар	сая.төг	хувиар
1. Бакалаврын сургалтын төлбөрийн авлага	87.1	6,234.0	2,502.9	2,415.8	28 дах	(3,731.1)	(59.8)
2. Магистрын сургалтын төлбөрийн авлага	122.4	30.9	314.0	191.6	156.5	283.1	916.2
3. Гадаад оюутны сургалтын төлбөрийн авлага			8.2	8.2	100.0	8.2	100.0
Бүгд дүн	209.5	6,264.9	2,825.1	2,825.1	1,248.5	(3,439.8)	(54.9)

Эргэлтийн бус хөрөнгө

2021 оны жилийн эцсийн байдлаар цэвэр хөрөнгийн дүнгээр (Анхны өртөг-Хуримтлагдсан элэгдэл) 69.0 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй ба эдгээр хөрөнгийн 87.7 хувийг барилга, байгууламж, 12.3 хувийг бусад хөрөнгийн дүн эзэлж байна. Барилга байгууламж нь 31.4 хувийн элэгдэлтэй байна.

Хүснэгт 3. Үндсэн хөрөнгийн бүтэц 2021.12.31 өдрийн байдлаар (тэрбум төгрөгөөр)

Эргэлтийн бус хөрөнгө	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Үндсэн хөрөнгө	67.8	72.7	75.1	75.6	78.0	96.8	79.8	83.1	85.1	88.2
Хуримтлагдсан элэгдэл	(35.4)	(37.9)	(38.9)	(39.4)	(42.3)	(41.6)	(14.3)	(18.3)	(22.4)	(27.7)
ҮХ-ийн цэвэр дүн	32.5	34.8	36.3	36.2	35.7	55.2	65.5	64.9	62.7	60.5
Үүнээс: Барилга	27.2	27.2	28.3	26.9	26.6	41.9	51.4	49.7	48.0	46.3
Сургалтын машин, т/т	3.2	3.8	3.9	5.2	4.9	8.2	8.3	9.0	8.4	7.9
Тавилга, хэрэгсэл	2.1	2.1	2.2	2.1	2.0	3.0	3.3	3.3	3.3	2.8

¹ 2020, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга №4

Номын фонд	1.9	2.0	2.1	2.2	2.5	2.4	2.7	2.9	3.1	3.4
Нийтийн тохижилт	0.4	0.6	2.0	6.2	14.7	0.5	4.2	4.6	4.6	8.1
Биет бус хөрөнгүүд	0.1	0.2	0.3	0.3	0.3	0.3	0.2	0.2	0.4	0.4
Нийт ЭБХ-ийн дүн	34.9	35.6	38.5	42.6	50.7	56.0	69.9	69.6	67.8	69.0

2019-2021 онд үндсэн хөрөнгө нийт дүнгээр өсөлттэй хэдий ч, үндсэн хөрөнгийн цэвэр дүн 2019-2020 онд 4.4 тэрбум төгрөгөөр, 2020-2021 онд 2.2 тэрбум төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн насжилтийн нөлөөлөл байгааг илтгэж байна.

Өр төлбөр ба өмч

2019-2021 онд өр төлбөрийн үлдэгдэл 1,369.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Богино хугацаатай өр төлбөрийн бүтэцэд урьдчилж орсон орлого нь дийлэнх хувийг эзэлдэг ба энэ нь манай үндсэн үйл ажиллагааны онцлогтой холбоотой. Хичээл сонголт хийгээд төлбөрөө төлдөг механизм нь санхүүгийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй, санхүүжилтийн оролцоотой байна гэсэн үг юм. Харин дансны өглөгийн хувьд буурсан үзүүлэлттэй байна.

Эзэмшигчдийн өмчийн дүн 2,570.6 сая төгрөг буюу 2.3 хувиар нэмэгдснийг бүтцээр нь харвал засгийн газрын оролцоо тогтвортой, өмчийн дахин үнэлгээний өөрчлөлт 11.9 тэрбум төгрөгөөр үр дүнг нэмэгдүүлсэн бол тайлант оны үр дүн жил бүр буурсан байна.

Хүснэгт 4. МУИС-ийн санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа (2019-2021)

Үзүүлэлтүүд	Тооцох журам	Стандарт норм	2019	2020	2021	Өөрчлөлт	
						2019-2021	2020-2021
<u>1. Санхүүгийн тогтворжилт</u>							
1.1 Өөрийн хөрөнгийн оролцоо	ӨК:НХ	≥ 50	96.74	95.40	94.43	(2.31)	(0.97)
1.2 Нийт өрийн харьцаа	ГК:ӨК	≤ 1.0	0.03	0.05	0.06	0.03	0.01
1.3 Ажлын капитал (сая төг)	ЭХ-БХӨ		40,166.63	45,017.89	46,425.20	6,258.6	1,407.3
1.4 Санхүүгийн уян хатан байдал	АК:ӨК		36.58	39.90	40.23	3.65	0.33
1.5 Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	АК:ЭХ		11.85	9.28	7.82	(4.03)	(1.46)
<u>2. Төлбөрийн чадвар</u>							
2.1 Өнөөгийн боломж	МХ:БХӨ	0.2-0.3	10.76	7.37	6.73	(4.03)	(0.64)
2.2 Ойрын боломж	ТХХ:БХӨ	0.8-1.0	10.98	8.60	7.19	(3.79)	(1.41)
2.3 Эргэлтийн хөрөнгийн харьцаа	ЭХ:БХӨ	2:01	91.56	89.23	87.22	(4.34)	(2.01)
2.4 Өр төлбөр ба авлагын харьцаа	БХӨ:АВЛ	≥1	4.56	0.81	2.2	(2.36)	(1.39)

Санхүүгийн тогтворжилтын хувьд үзүүлэлтүүдийг нь өмнөх онуудтай харьцуулбал буурсан боловч төсвийн санхүүжилт болон бусад гадаад эх үүсвэрээс хараат бусаар үндсэн ажиллагааны орлогоороо урсгал зардал төдийгүй хөрөнгө оруулалтын хэсгийг санхүүжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Өөрийн хөрөнгийн оролцоо 94.4 хувь болж тогтвортой байгаа нь бизнесийн байгууллагын хэвийн нормоос 40.0 гаруй хувиар буюу бараг 2 дахин илүү, өрийн харьцаа нь 17 дахин бага, эргэлтийн хөрөнгийн 87.2 хувийг зөвхөн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байна.

2019-2021 онд томоохон хөрөнгө оруулалттай холбоотойгоор санхүүжилт өмнөх онуудаас бага тул санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын зарим үзүүлэлтүүд төлбөрийн өнөөгийн болон ойрын боломж стандарт дунджаас нилээдгүй өндөр байгаа нь санхүүгийн хувьд тогтвортой, хөрөнгө оруулалтын зориулалтаар хуримтлал бий болсон байна. Хуримтлагдсан нөөц хөрөнгийг оновчтой байршуулан, эргэлтэд оруулах замаар сургалт, судалгааны ажлын материаллаг баазыг шинэчлэн сайжруулах боломжтойг илэрхийлж байна.

2019 оны эцсийн байдлаар МУИС-ийн нийт хөрөнгийн бараг 61.4 хувийг эргэлтийн бус (удаан гүйлгээтэй) хөрөнгөнүүд эзэлж байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 56.4 хувь болж буурсан ба өнгөрсөн 3 жилд 664.7 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсныг хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлъя.

Хүснэгт 5. МУИС-ийн эргэлтийн бус хөрөнгийн бүрэлдэхүүн, өөрчлөлт (2019-2021)

Хөрөнгийн бүрэлдэхүүн	2019		2020		2021		2019-2021 оны өөрчлөлт	
	сая төг	х/ж	сая төг	х/ж	сая төг	х/ж	сая төг	%
Үндсэн хөрөнгө	83,134.50	119.4	85,102.30	125.5	88,205.50	127.9	5,071.00	6.1
Хуримтлагдсан элэгдэл	(18,272.50)	(26.2)	(22,381.00)	(33.0)	(27,686.50)	(40.1)	9,413.90	51.5
1. УХ-ийн цэвэр дүн, бүгд	64,861.90	93.2	62,721.30	92.5	60,519.00	87.8	(4,342.90)	(6.7)
Үүнээс: Барилга байгууламж	49,727.60	71.4	48,013.40	70.8	46,327.00	67.2	(3,400.60)	(6.8)
Сургалтын Т/т	9,002.10	12.9	8,401.70	12.4	7,948.70	11.5	(1,053.40)	(11.7)
Тавилга, эд хогшил	3,315.20	4.8	3,298.10	4.9	2,786.90	4.0	(528.3)	(15.9)
Номын фонд	2,943.90	4.2	3,148.20	4.6	3,354.10	4.9	410.2	13.9
2. Нийтийн тохижилт, бусад	4,593.20	6.6	4,641.30	6.8	8,078.00	11.7	3,484.90	75.9
3. Дуусаагүй бар/байгууламж	160	0.2	160	0.2	3,819.80	5.5		
4. Биет бус хөрөнгө	174	0.2	435.4	0.6	367.3	0.5	193.3	111.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	69,629.00	100.0	67,798.00	100.0	68,964.30	100.0	(664.7)	(0.9)

Үндсэн хөрөнгө 2019-2021 онд нийт 5,070.1 сая төгрөгөөр буюу 6.1 хувиар, харин үндсэн хөрөнгийн цэвэр дүн 4,342.9 сая төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан, үүний 3,400.6 сая төгрөг буюу 6.8 хувиар нь барилга байгууламж, 1,053.4 сая төгрөг буюу 11.7 хувиар сургалтын тоног төхөөрөмж 528.3 сая төгрөг буюу 15.9 хувиар сургалтын тавилга, эд хогшлын дүн буурсан байна.

Хичээлийн 7 дугаар байр, багш оюутны үйлчилгээний төвийн барилгын ажилд 2018 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийхээр жил жилээр төсөв хуримтлуулан бүрдүүлж 2021 онд БОУТ-ийн барилгын ажлыг эхлүүлж 3,819.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн үлдсэн төсөв нь мөнгөн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлсэн байна. Мөн өнгөрсөн 3 жилийн хугацаанд номын фондын шинэчлэл, биет бус хөрөнгийн шинэчлэл /программ хангамж/-ийн хувь хэмжээ нэмэгдсэн байна.

2021 оны эцсийн байдлаар МУИС-ийн хэмжээнд 88,205.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн 40.1 хувийг элэгдэл эзэлж байгаа бөгөөд барилга байгууламжийнх 31.4 хувийн, сургалтын тоног төхөөрөмж болоод сургалтын тавилга эд хогшил тус бүр 67.3 хувийн элэгдэлтэй байгаа нь хөрөнгийн шинэчлэлийг цаг алдалгүй шинэчилж байх шаардлага байгааг илтгэж байна. Ялангуяа сургалтын тоног төхөөрөмжийн технологийн дэвшил хурд ихтэй үед дагасан

шинэчлэлийг хийж байх шаардлага байна. Эзэмшигчийн өмчийн дүн 2019-2021 онд 5,593.9 сая төгрөгөөр сая төгрөгөөр нэмэгдсэн нь (хүснэгт 1) гагцхүү он тус бүрийн үндсэн ажиллагааны зардлаас давсан орлого буюу цэвэр ашгаар хангагдсан гэж тайлагнажээ. Өнгөрсөн онуудад төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийгдээгүй тул засгийн газрын оруулсан хөрөнгийн дүн тогтмол байна. Гэвч Гэгээрлийн сайдын 1999 оны Гэгээрлийн сайдын 107 дугаар тушаал “Сургалтын төлбөрийг тогтоох аргачлал”-д хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төсвөөс бүрдүүлэхээр заасан хэдий ч хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Үндсэн хөрөнгийн өсөлтийн хэдийг нь сургуулийн хуримтлагдсан нөөцөөр, хэдий хэсгийг төсөл хөтөлбөр сангаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлснийг дараах байдлаар харж болно.

Хүснэгт 6. МУИС-ийн үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт (2019-2021)* (сая төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2019	2020	2021	ӨӨРЧЛӨЛТ		
	дүн	дүн	дүн	2019-2021		
				дүн	хувийн жин	хувиар
БҮГД ДҮН	4,329.3	3,398.2	6,591.1			
ХАНДИВААР /ҮҮНЭЭС/	751.4	193.6	356.4			
-БУСАД ЯАМ, АГЕНТЛАГ /БСШУЯ -ААС БУСАД/		5.9	17.2			
-ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, САН		120.1				
-БУСАД	751.4	67.7	339.2			
ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР	3,577.9	3,204.6	6,234.9			
ГАДНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР БЭЛТГЭСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН	17.4%	5.6%	5.4%			

*Дээрх дүн дотоод шилжүүлгийн дүн ороогүй болно.

Дээрх мэдээллээр бусад эх үүсвэрээр олж бэлтгэсэн хөрөнгө их харагдаж байгаа боловч бодит байдал дээр төслийн хөрөнгөөр ихээхэн хөрөнгө олж авдаг тул бүртгэлийн эх үүсвэрийг зөв тайлагнах нь хэрэгтэй. БСШУЯ-наас гадна бусад яам, агентлагууд нь чиглэлийнхээ үйл ажиллагааг дэмжин хөрөнгө оруулалт хийдэг байна. 2021 онд өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалт 6.2 тэрбумд хүрсний 3.5 тэрбум төгрөг буюу 56,4 хувь нь БОҮТ-ийн барилгын хөрөнгө оруулалт байна. Нийт хөрөнгө оруулалтад эзлэх бусад хөрөнгө оруулалтын хувь хэмжээ жилээс жилд буурсан байгаа нь нэг талаас цар тахалтай холбоотой ч нөгөө талаас бодлогийн түвшинд сургуулийн материаллаг бааз, сургалтын орчинг сайжруулахад өөрийн хөрөнгөөс гадна бусад хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө босгох ажлыг зохион байгуулах, идэвхжүүлэх нь хэрэгтэй.

Хоёр. Санхүүгийн үр дүнгийн зэрэгцүүлэлт (Хавсралт-2)

МУИС нь жил тутмын орлогын 90 гаруй хувийг зөвхөн өөрийн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлж ашиглалтын тогтмол зардал болон хөрөнгө оруулалтын зарим хэсгийг л төсвийн санхүүжилтээр авдаг байсан бол дээд боловсролын тухай хуулинд өөрчлөлт орж тогтмол зардлын санхүүжилт зогссон байна.

2021 оны санхүүгийн нэгдсэн тайлангаар МУИС-ийн хэмжээнд нийтдээ 56,513.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнийхээ 95.4 хувийг урсгал зардалд зарцуулан орлогынхоо 4.1 хувьтай тэнцэхүйц цэвэр үр дүнтэй ажиллажээ. МУИС-ийн нэгдсэн орлого сүүлийн 3 жилд (2019-2021 онд) 4,362.5 сая төгрөгөөр буюу 7.17 хувиар буурсан, харин урсгал зардал нь мөн хугацаанд 1,757.6 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна. МУИС-ийн нийт орлого болон зардлыг зэрэгцүүлэхэд зарлагаас давсан орлого нь 2021 онд 2,573.6 сая төгрөг болж 2019 оныхоос 6,120.1 сая төгрөгөөр буюу 2.3 дахин буурч, нийт орлогын нэгжид буюу нэг төгрөгийн орлогод ногдох зардал 95 мөнгө болж 2019 оноос 09 мөнгөөр, 2020 оноос 1 мөнгөөр өссөн бол зарлагаас давсан орлогын үр дүн 2020 оныхоос 856.9 сая төгрөгөөр буюу 24.9 хувиар буурч сүүлийн 3-н оны санхүүгийн үр дүн бууралттай гарсан байна.

Хүснэгт 7. МУИС-ийн санхүүгийн нэгдсэн үр дүн²

Үзүүлэлт		Гүйцэтгэл, сая төгрөгөөр			Өөрчлөлт			
		2019	2020	2021	2019-2021 онд		2020-2021 онд	
					сая.төг	хувиар	сая.төг	хувиар
1. Үндсэн ажиллагааны	Орлого	60,527.3	53,198.7	56,488.7	(4,038.5)	(6.67)	3,290.0	6.18
	Зардал	50,318.0	50,181.5	53,874.1	3,556.1	6.60	3,692.6	7.36
	Үр дүн	10,209.3	3,017.2	2,614.7	(7,594.6)	(74.39)	(402.5)	(13.34)
	Орлогод харьцуулсан %	16.9%	5.7%	4.6%		(12.3%)		(1.1%)
2. Үндсэн бус ажиллагааны	Орлого	348.9	569.8	24.9	(324.0)	(92.86)	(544.9)	(95.62)
	Зардал	1,864.5	156.5	66.0	(1,798.5)	(96.46)	(90.5)	(57.84)
	Үр дүн	(1,515.5)	413.3	(41.1)		(97.3)		1.1 дах
3. Бүгд	Орлого	60,876.2	53,768.5	56,513.7	(4,362.5)	(7.17)	2,745.2	5.11
	Зардал	52,182.5	50,338.0	53,940.1	1,757.6	3.37	3,601.1	7.16
	Үр дүн	8,693.7	3,430.5	2,573.6	(6,120.1)	(70.40)	(856.9)	(24.98)
	Орлогын 1 төгрөгт ногдох зардал, (мөнгөөр)	0.86	0.94	0.95	0.09	10.5%	0.01	1.1%


Зардлаас давсан орлогын нөлөөллийг орлогын бүрэлдэхүүнээр нь авч үзэхэд 2019 онд сургалтын төлбөрийн авлага цуглуулалт хэвийн үйл ажиллагаатай байсан бол 2020, 2021 онуудад ковид-19-тэй холбоотой Засгийн газрын шийдвэрээр сургалтын төлбөрийн тодорхой хэсгийг хугацаатай хойшлуулах үүрэг өгч авлага цуглуулалтын хоногийг нэтэгдүүлсэн байна. Үүний улмаас хичээл сонголтынхоо 50%-ийг шууд төлөх, үлдсэн 50%-ийг дараа төлөх нөхцөл бий болсноор сургалтын төлбөрийн авлага нэмэгдэж тайлант хугацааны орлогын дүн буурахад нөлөөлсөн байна.

2021 оны үндсэн бус үйл ажиллагааны үр дүнгийн бууралтад гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 2019 онд 301.1 сая төгрөг, 2020 онд 527.8 сая төгрөг, 2021 онд 41.1 сая төгрөг болж сүүлийн 3 жилийн үр дүнгийн үзүүлэлт буурсан нь нөлөөлжээ. Он дараалан огцом өсөлт, уналттай байгаа нь гадаад валют болох Америк долларын ханш тогтворгүй ихээхэн хэлбэлзэлтэй байгаатай холбоотой юм. Үйл ажиллагааны бус зардлын дүнд үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 2019 онд 13.4 сая төгрөг буюу 0.7 хувь, найдваргүй авлагын алдагдал 1,803.3 сая төгрөг буюу 96.7 хувь (тогмол зардлын санхүүжилт 1.8 төгрөгийн авлагыг найдваргүй болгож үр дүн рүү хаасан), 2020 онд хөрөнгө данснаас хассаны гарз 30.9 сая төгрөг буюу 19.7 хувь, найдваргүй авлагын алдагдал 83.6 сая төгрөг буюу 53.4 хувийг эзэлж байна.

² 2019,2020,2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

2019-2021 оны нийт үр дүнгийн өсөлт 2,573.6 сая төгрөгийг дан ганц үндсэн ажиллагааны цэвэр орлогоор бүрдүүлсэн нь сайшаалтай байна. 2019-2021 он үндсэн ажиллагааны цэвэр үр дүн жил жилээр буурсан үзүүлэлттэй байгаа нь орлого хүлээн зөвшөөрөх бодлогод өөрчлөлт орж зөвхөн баталгаажуулсан хичээл сонголтоор орлого хүлээн зөвшөөрч байгаатай холбоотой байна. Үндсэн үйл ажиллагааны үр дүн орлогод харьцуулсан хувь 2019 онд 16.9 байсан бол 2021 онд 4.6% болж буурахад 2019 оноос 12.3%-иар буурсан нь тус сургуулийн үндсэн үйл ажиллагааны орлогод сургалтын төлбөрийн авлага цуглуулах шийдвэрийн нөлөөлөл ихэсэж эрсдэл бий болох болзошгүй байна. Сүүлийн 3 жил дараалан орлогод харьцуулсан зардлын хувь тогтвортой өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. МУИС-ийн орлого ба зарлагын өсөлт (2017 -2021)




МУИС-ийн 2019-2021 оны нэгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого болон зардлын ерөнхий дүр зураг нь орлого ба зардлын хувьд харьцангуй тогтвортой хараат бус, бие даасан төлбөрийн чадварын хувьд тогтмол сайжирч байгааг илтгэж байна. Мөн он дараалан нэг төгрөгийн орлого олоход зарцуулж буй зардал өсч байгаа нь зардал тайлант хугацааны орлогоос давах эрсдлийг үүсгэж болзошгүй тул хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж зохистой зарцуулахад чиглүүлэх хэрэгтэй.

МУИС-ийн 2021 оны нэгдсэн тайлангаар үндсэн ажиллагааны орлого 56,448.7 сая төгрөг болж 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 4,038.5 сая төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан үүний 8.3 хувийг төсвийн санхүүжилт, 22.6 хувийг ЭШ, төсөл хөтөлбөр гэрээт ажил, 43.9 хувийг туслах үйл ажиллагааны орлого, 39.0 хувийг бусад хандив тусламжийн орлого эзэлж байсан бол 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 3,290.0 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн, үүний 13.3 хувийг төсвийн санхүүжилт, 142.8 хувийг сургалтын төлбөр, 39.6 хувийг ЭШ, төсөл хөтөлбөр, гэрээт ажил, 14.5 хувийг туслах үйл ажиллагааны орлого тус тус бүрдүүлсэн бол хандив тусламж бусад орлого 109.9 хувиар буурсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын бүтцийг 2019-2021 оны дунджаар авч үзвэл 80.0 хувь нь сургалтын төлбөр, 6.9 хувь нь эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, 7.8 хувь хандив тусламж бусад (хадгаламжийн хүүгийн орлого), 4.2 хувь нь туслах үйл ажиллагаа, үлдсэн 1.2 хувь нь төсвийн санхүүжилт буюу тогтмол зардлын санхүүжилт юм.

Зураг 3. МУИС-ийн орлого, зарлагын бүтэц (2019-2021 оны гүйцэтгэлээр)

МУИС-ийн үндсэн ажиллагааны орлого болон зардлыг тус бүрд нь бүрэлдэхүүн хэсгүүдээр нь судлан тодорхойлбол:



Эндээс дүгнэвэл сургуулийн үндсэн ажиллагааны орлого болох сургалтын төлбөрийн орлогоос бусад эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөрийн орлогын нийт дүн 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 4.1 тэрбум төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан байна. Орлогын бүрэлдэхүүний хувьд 2019-2021 онд тухайн жилийнхээ орлогод эзлэх хувийн жин нэмэгдэж харагдаж байгаа хэдий ч сургалтын төлбөрийн бусад үйлчилгээний орлогын хэмжээ буурах хандлагатай байна. Цааш нь орлогын энэ өсөлтийг хангахад бүрэлдэхүүний сургууль, нэгжүүдийн оролцоо, тэдгээрийн сургалтын бусад үйлчилгээний (эрдэм шинжилгээний гэрээт төсөл, судалгааны төсөл, патент болон зохиогчийн эрхийн) орлогын өсөлтийг нэмэгдүүлэх дорвитой ажлуудыг хийх шаардлагатай байна.

Хүснэгт 8. МУИС-ийн үндсэн ажиллагааны орлогын бүтэц, өсөлт

Үзүүлэлт	Хувийн жин			Өөрчлөлт					
	2019	2020	2021	2019-2021 онд			2020-2021 онд		
				сая.төг	х/жин	хувиар	сая.төг	х/жин	хувиар
1. Төсвийн санхүүжилт	1.30	0.60	1.80	(336.30)	(0.56)	(8.33)	438.80	0.82	13.34
2. Сургалтын төлбөрийн орлого	83.40	79.70	76.90	563.70	0.93	13.96	4,699.50	8.83	142.84
3. ЭШ, төсөл, хөтөлбөрийн орлого	7.20	5.20	8.20	(913.60)	(1.51)	(22.62)	1,301.50	2.45	39.56
4. Туслах үйл ажиллагаа	3.50	2.80	6.20	(1,775.90)	(2.93)	(43.97)	465.40	0.87	14.15
3. Хандив тусламж ба бусад	4.60	11.70	6.90	(1,576.40)	(2.60)	(39.03)	(3,615.10)	(6.80)	(109.88)
Үндсэн ажиллагааны орлогын дүн	100.00	100.00	100.00	(4,038.50)	(6.67)	100.00	3,290.10	6.18	100.00

МУИС-ийн 2024 он хүртэлх хэрэгжүүлэхээр баталсан стратеги төлөвлөгөөний хүрээнд дунд болон урт хугацаанд судалгаа, эрдэм шинжилгээний ажил, төслийн орлогын жил тутам нэмэгдүүлэх 2021 онд нийт орлогын хүртэлх 15 хувийг судалгаа, эрдэм шинжилгээний орлогоос бүрдүүлэх зорилгийн хэрэгжилт үр дүнгээр 8.2 хувьтай байна. Мөн хандив тусламжийн орлого нийт орлогын 4.6-6.9 хувийн дотор хэлбэлзэж байгаа нь МУИС-ийн 2024 он хүртэлх хэрэгжүүлэхээр зорьж буй стратеги төлөвлөгөөнд хандивын болоод тусламжийн орлогын нэмэгдүүлэх ажлуудыг бодит ажил болгох нь туйлын шаардлагатай байна.

Харин үндсэн үйл ажиллагааны зардлын бүтцийг 2019-2021 оны дунджаар авч үзвэл дийлэнх хэсэг буюу 63.8 хувь нь ажиллагчидтай холбоотой буюу цалин хөлс, урамшуулал нийгмийн даатгалын шимтгэл, үлдсэн хэсэг болох 36.2 хувь нь бараа үйлчилгээний зардал тус тус эзэлж байна. Сүүлийн 3 жилийн дунджаас дүгнэхэд дээрх зардлууд (ажиллагчидтай холбоотой болон бараа үйлчилгээний) харьцангуй тогтвортой 3:1 гэсэн харьцаатай хадгалагдаж байна.

МУИС-ийн үндсэн ажиллагааны урсгал зардлын гүйцэтгэл 2021 оны үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл нь 2019 оноос 3,556.0 сая төгрөг буюу 7.1 хувиар, 2020 оноос 3,692.5 сая төгрөг буюу 7.4 хувиар өссөн байна. Үүнээс ажиллагчидтай холбоотой зардлын хувь дундажаар 3.2 пунктээр өссөн, харин бараа үйлчилгээний зардлын хувь дундажаар 3.3 пунктээр буурсан байна. Үйл ажиллагааны зардал өссөн байхад харгалзах орлого нь буурсан үзүүлэлттэй байгаа нь цуглуулсан үйл ажиллагааны орлого, ялангуяа сургалтын төлбөрийг хэмнэлттэй, зориулалтаар нь үр өгөөжтэй зарцуулах хэрэгтэйг тайлбарлаж байна.

Хүснэгт 9. МУИС-ийн үндсэн ажиллагааны урсгал зардлын бүтэц, өсөлт

Үзүүлэлт	Хувийн жин			Өөрчлөлт					
	2019	2020	2021	2019 – 2021			2020 – 2021		
				сая.төг	х/жин	хувиар	сая.төг	х/жин	хувиар
1. Ажиллагчидтай холбоотой	60.6	65.8	64.9	4,401.10	8.7	123.8	1,894.40	3.8	51.3
2. Бараа үйлчилгээний зардал, бүгд	39.4	33.9	35.1	-845.2	-1.7	-23.8	1797.9	3.6	48.7
Үүнээс: Ашиглалтын	2.2	1.9	1.7	-191.3	-0.4	-5.4	-11.8	0.0	-0.3
Хангамж бараа материалын	2.2	2.4	2.1	55.4	0.1	1.6	-72.5	-0.1	-2.0
Эд хогшил, урсгал засварын	1.4	2.5	2.5	697.6	1.4	19.6	159.4	0.3	4.3
Томилолт, зочны зардал	1.4	0.2	0.4	-516.1	-1.0	-14.5	99.4	0.2	2.7
Төлбөр хураамж, БГАУ	1.3	1.6	1.9	385.1	0.8	10.8	192.7	0.4	5.2
Хөтөлбөр арга хэмжээ	1.4	1.5	1.7	216.9	0.4	6.1	170.4	0.3	4.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18.7	12.3	13.7	-2,066.30	-4.1	-58.1	1,188.10	2.4	32.2
ҮХ-ийн элэгдэл хорогдол	9.6	10.4	10	547.8	1.1	15.4	162.8	0.3	4.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1.2	1.1	1.1	25.7	0.1	0.7	-90.6	-0.2	-2.5
Үндсэн ажиллагааны зардлын дүн	100.0	100.0	100.0	3,556.00	7.1	100.0	3,692.50	7.4	100.0

2021 оны гүйцэтгэлээр МУИС-ийн үндсэн ажиллагааны нийт зардлын 64.9 хувийг “ажиллагчдын цалин шимтгэлийн зардал” эзэлж байгаа нь өмнөх онуудаас (2019 оныхоос) 4.3 пунктээр өссөн, 2020 оныхоос 0.9 хувиар буурсан байна. Харин үндсэн ажиллагааны зардлын үлдсэн хэсэг буюу 35.1 хувийг “бараа үйлчилгээний зардал” эзэлж байгаа нь өмнөх онуудаас тус бүр (2019 оныхоос 4.3 пункт буурсан, 2020 оныхоос 0.9 пункт өссөн) байна. Бараа үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн зардал болох 9 төрлийн зардлын нийт бараа үйлчилгээний зардалд эзэлж буй хувийг дээрх (хүснэгт 9)-ээс харж болно.

МУИС-ийн 2024 он хүртэлх хөгжүүлэх стратеги төлөвлөгөөндөө тус сургуульд хэрэгжүүлж буй бүх хөтөлбөрөө үндэсний хэмжээнд, шинжлэх ухаан инженерчлэлийн хөтөлбөрүүдийн 50 хувийг олон улсын магадлан итгэмжлүүлэхээр тусгасан бөгөөд энэхү зорилтын хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилээс магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагатай болгох ажиллагааг зохион байгуулсан, хөтөлбөр сурталчлах, сонгох үйл ажиллагааг жилд 2 удаа болгож мэдээллийг хүртээмжтэй хүргэж сонгуулах тал дээр анхаарч ажилласан нь 2019 онд оны хичээл практикийн зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болсон байна.

Энэ нь бараа үйлчилгээний зардлын гүйцэтгэл нь 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 845.2 сая төгрөг буюу нийт зардлын хэмнэлтийн 23.8 хувиар бүрдүүлсэн (тэр дундаа хичээл үйлдвэрлэлийн дадлага 58.1 хувийн бууралтыг эзэлж) байгааг тодорхойлж байна. Харин 2019 оны гадаад арга хэмжээний зардал нь нийт үйл ажиллагааны зардлын 1.4 хувьд хүрсэн нь зориулалтын хувьд үр өгөөжгүй зарцуулалт болжээ. 2020 оны хувьд цар тахлын үе таарсан нь үйл ажиллагааны хүрээ хумигдаж цалингаас бусад зардал нилээн хэмнэгдсэн дүн харагдаж байна. 2021 оны гүйцэтгэлийг 2020 онтой харьцуулахад 3,692.5 сая төгрөг буюу 7.4 хувиар өссөн нь үйл ажиллагаа хэвийн түвшин рүү шилжиж байгааг илтгэсэн байна. Зардлыг бүтцээр авч дүгнэвэл ашиглалтын болон хангамж бараа материал, тэтгэвэр тэтгэмжийн зардлын хувьд 2020 оны түвшингээс буурсан үзүүлэлттэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал зардлын зонхилох хэсэг (64.9 орчим хувь) болох ажиллагчидтай холбоотой цалин шимтгэлийн зардлыг МУИС- ийн хэмжээнд төдийгүй бүрэлдэхүүний нэгж, сургууль тус бүрээр батлагдсан орон тоо, гүйцэтгэсэн хичээл сургалтын болоод эрдэм шинжилгээний ажил, дундаж цалингийн өсөлтийн нөлөөллөөр судлан, цалин хөлсний зардал аль нэгжүүдэд болон албан тушаалаар хэрхэн өөрчлөгдсөн, түүний шалтгааныг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган орууллаа.

Санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын тайлангийн тоо мэдээллийг ашиглан оруулсан хөрөнгийн ашиглалт өгөөжийн үзүүлэлтүүдийг тооцоолоход.

Хүснэгт 10. Санхүүгийн үр дүнгийн харьцаанууд (2019-2021 он)

Үзүүлэлтүүд	Тооцох журам	2019	2020	2021	Өөрчлөлт	
					2019-2021	2020-2021
1. Хөрөнгийн ашиглалт						
1.1 Нийт хөрөнгийн ачаалал	НО÷НХ	0.53	0.45	0.46	-0.07	0.01
1.2 Авлагын цуглуулалт	Авл *360 : СО	4.80	53.21	21.60	16.80	-31.61
1.3 БМН- ийн эргэц	Н*360 : БҮЗ	50.10	68.98	70.13	20.05	1.15
1.4 Үйл ажиллагааны мөчлөг	1.2 +1.3	54.88	122.19	91.73	36.85	-30.46
2. Хөрөнгийн өгөөж, хувиар						0.00
2.1 Нийт хөрөнгийн өгөөж	НҮД : НХ	7.66	2.90	2.11	-5.55	-0.79
2.2 Өөрийгөө санхүүжүүлэх чадвар	(НО-ТС) : ҮАЗ	118.1	105.4	103.4	-14.67	-1.93
2.3 Туслах үйл ажиллагааны орлогын хувь	(НО-ӨО) : НО	6.20	2.84	3.49	-2.70	0.66
2.4 Орлогын 1 төгрөгт ногдох зардал (мөнгөөр)	НЗ : НО	0.83	0.94	0.95	0.12	0.01

Нийт хөрөнгийн нэгжид ногдох орлого 2019-2021 онд ялимгүй буюу 0.07 пунктээр, 2020-2021 онд эргээд 0.01 пунктээр буурчээ. 2021 оны гүйцэтгэлийг нь ерөнхийд дүгнэвэл 2019 онд 5 хоногт авлагаа цуглуулж чаддаг байсан бол 2020 онд хагас нэг сар хагас , 2021 онд сар орчим хоногоор удааширч харин бараа материалын нөөцийн эргэц 20 хоногоор тус бүр түргэсэж бүхэлдээ 60 хоногийн буюу хоёр сар гаруйн нөөц хадгалагдаж 2019 оны гүйцэтгэлээс 60 гаруй

хоногоор нэмэгджээ. Нийт хөрөнгийн өгөөж 2021 онд 2.1 хувь болсон нь 2019 оныхоос 3 дахин багассан 2020 оны гүйцэтгэлээс 0.79 пунктээр буурсан байна.

Төсвийн санхүүжилтийг оруулахгүйгээр тооцоход МУИС-ийн өөрийн бий болгосон орлогоор өөрийгөө санхүүжүүлэх чадвар 2019 онд 14.7 пункт болж 2020 оныхоос 1.9 пунктээр буурчээ. Хэдийгээр буурсан ч төсвийн санхүүжилтээс үл хамааран үйл ажиллагааны зардал санхүүжүүлэх бүрэн боломжтой байгааг илтгэж байна.

Туслах үйл ажиллагааны (мэргэжлийн үйлчилгээ гэх мэт) орлогын хувийг нийт орлогоор тооцоход 3.5 хувь болж 2019 оныхоос 2.7 пунктээр буурсан боловч сүүлийн 2020 оноос харьцангуй тогтворжсон төлөвтэй байна. Сүүлийн 3 жил дараалан нэгж (1 төгрөгт ногдох) орлогод ногдох зардлын хэмжээ өснөөр цэвэр үр дүнгийн хэмжээ буюу (ашгийн хувь) нь буурч, тэр хэмжээгээрээ эздийн өмчийг бууруулан цаашлаад нийт үр дүн бууруулж байна. Иймээс орлогыг үр дүн, үр өгөөжтэй зарцуулах, стратегийн зорилго зорилтууд болон тусгасан KPI-г хангах үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээнд зориулах, сургалтын төлбөрөөс бусад орлогын хувь хэмжээг нэмэгдүүлж үр дүнг өсгөх шаардлагатай.

Гурав. Мөнгөн гүйлгээний тайлангийн зэрэгцүүлэлт

Мөнгөн гүйлгээний тайлан нь хаанаас ямар эх үүсвэрээр мөнгөн орлого орж ирсэн, түүнийг чухам юунд төсөвлөн зарцуулсныг мөнгөн сууриар илэрхийлдэг, байгууллагын мөнгөн орлого ба зарлагыг урьдаас төсөвлөн, төлбөрийн чадварыг хянахад маш чухал ач холбогдолтой, байгууллагын санхүүгийн үр дүн болон төсвийн гүйцэтгэлтэй уялдсан тайлан байдаг.

МУИС-ийн нэгдсэн тайлангаар 2021 онд нийтдээ 60,708.2 сая төгрөгийн мөнгөн орлого орж ирсний 86.5 хувь нь өөрийн буюу үндсэн үйл ажиллагааны, үүнээс 73.1 хувь нь зөвхөн сургалтын төлбөрийн орлого байжээ. Энэ бүрдүүлсэн орлогынхоо 80.1 хувийг үндсэн ажиллагаанд, 9.5 хувийг хөрөнгө оруулалт (барилга, их засвар, үндсэн хөрөнгө худалдан авах гэх мэт)-нд, үлдсэн хэсэг болох 10.4 хувийг цэвэр гүйлгээ буюу мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг нэмэгдүүлсэн байна. 2021 оны гүйцэтгэлээр цэвэр гүйлгээ буюу мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг нийтдээ 5,779.5 сая төгрөгөөр л нэмэгдүүлжээ.

МУИС-ийн нийт мөнгөн орлого болон мөнгөн зарцуулалт 2019-2021 онд тус бүр 4.4-10.2 хувиар нэмэгджээ. Мөнгөн орлого дүн 2019 оныхоос 2,575.7 сая төгрөгөөр буюу 4.43 хувиар, 2020 оныхоос 14,183.6 сая төгрөгөөр буюу 30.5 хувиар нэмэгдсэн нь 100 хувь үндсэн ажиллагааны орлогын санхүүжилт байна.

Мөнгөн зарлагын дүн 2021 онд 2019 оноос 5,072.5 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар нэмэгдсний 52.9 хувь хөрөнгө оруулалтын зардал, харин 2020 оныхоос 8,598.0 сая төгрөгөөр 18.6 хувиар нэмэгдсний 37.2 хувь нь хөрөнгө оруулалтын зардал байна. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд зөвхөн үндсэн ажиллагааны мөнгөн орлогоор л үндсэн ажиллагаа төдийгүй хөрөнгө оруулалтын болон санхүүгийн мөнгөн зарлагыг санхүүжүүлж байсан дүр зураг харагдаж байна.

Мөнгөн орлогын, тэр дундаа төсвийн санхүүжилтийн орлогын чухам хэдий хэсэг нь үндсэн ба санхүүгийн, бас хөрөнгө оруулалтын зориулалттай орлого болох, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэдий хэсгийг өөрийн, хэдий хэсгийг төсвийн санхүүжилтээр нөхсөнийг ялган салгаж тайлагнаж байх нь мөнгөн урсгалын удирдлага, гүйцэтгэлийн хяналт болон шинжилгээ дүгнэлтэд чухал ач холбогдолтой.

Хүснэгт 11. МУИС-ийн нэгдсэн мөнгөн орлого, зарлагын зэрэгцүүлэлт (Үйл ажиллагааны төрлүүдээр)

Мөнгөний урсгал	Гүйцэтгэл, сая төгрөгөөр			Өөрчлөлт			
	2019	2020	2021	2019 - 2021		2020- 2021	
				сая.төг	хувиар	сая.төг	хувиар
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	31,567.2	39,843.4	40,037.2	8,470.0	26.8	193.8	0.5
1.Үндсэн ажиллагааны							
Мөнгөн орлого	58,132.5	46,524.6	60,708.2	2,575.5	4.43	14,183.6	30.5
Мөнгөн зарлага	46,214.0	43,266.0	48,623.7	2,409.7	5.21	5,357.7	12.4
Цэвэр гүйлгээ	11918.5	3,258.6	12,084.5	166.0	1.39	8,825.9	270.8
2.Хөрөнгө оруулалтын							
Мөнгөн орлого							
Мөнгөн зарлага	3,642.3	3,064.8	6,305.1	2,662.8	73.1	3,240.3	105.7
Цэвэр гүйлгээ	(3,642.3)	(3,064.8)	(6,305.1)	(2,662.8)	73.1	(3,240.3)	105.7
Нийт							
Мөнгөн орлого	58,132.5	46,524.6	60,708.2	2,575.7	4.4	14,183.6	30.5
Мөнгөн зарлага	49,856.3	46,330.8	54,928.8	5,072.5	10.2	8,598.0	18.6
Цэвэр гүйлгээ	8,276.2	193.8	5,779.4	(2,496.8)	(30.2)	5,585.6	2,882.1
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,843.4	40,037.2	45,816.7	5,973.3	15.0	5,779.5	14.4

Энэ нь эцсийн дүндээ МУИС-ийн бүрэлдэхүүний сургууль, нэгжүүдийн тайлагналын чанар, мөнгөн зарцуулалтын ил тод байдалтай холбоотой юм. МУИС-ийн Мөнгөн гүйлгээний нэгдсэн тайлангийн мэдээллээр үзэхэд 2019-2021 онуудад нийт мөнгөн орлого 100.0 хувь зөвхөн үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдэж иржээ.

Хүснэгт 12. МУИС-ийн нэгдсэн мөнгөн орлогын бүрдүүлэлт

Орлогын бүрэлдэхүүн	Гүйцэтгэл, сая төгрөгөөр			Өөрчлөлт			
	2019	2020	2021	2019-2021		2020-2021	
				сая.төг	хувиар	сая.төг	хувиар
Үйл ажиллагааны орлого, бүгд	58,132.5	46,524.6	60,708.2	2,575.7	4.43	14,183.6	30.5
Үүнээс: 1.1. Төсвийн санхүүжилт	8,226.1	1,542.1	8,207.9	(18.2)	(0.22)	6,665.8	432.25
1.1.1 БЗС-аас	7,139.4	1,086.6	7,090.2	(49.2)	(0.69)	6,003.6	552.51
1.1.2 ШУТС-аас	976.1	341.2	1,004.4	28.3	2.90	663.2	194.37
1.1.3 БЭЛАС х/зардал	110.5	114.3	113.4	2.9	2.62	(0.9)	(0.79)
1.2 Өөрийн үйлчилгээний	49,906.4	44,982.5	52,500.3	2,593.9	5.20	7,517.8	16.71
Үүнээс: 1.2.1. Сургалтын төлбөр	38,255.8	36,851.5	44,398.4	6,142.6	16.06	7,546.9	20.48
1.2.2 Туслах үйл ажиллагаа, бусад	11,650.6	8,131.0	8,101.8	(3,548.8)	(30.46)	(29.2)	(0.36)
2. Хөрөнгө оруулалтын төсвийн санхүүжилт							
3. Санхүүгийн орлого							
Мөнгөн орлогын бүгд дүн	58,132.5	46,524.6	60,708.2	2,575.7	4.43	14,183.6	30.49

Төсвийн санхүүжилт 2019 оноос 18.2 сая төгрөг буюу 0.22 хувиар буурсан, 2020 оноос 4.3 дахин өссөн үзүүлэлттэй, 2020-2021 онд тусгай үйл ажиллагааны зориулалттай улсын төсвийн санхүүжилттэй мөнгөн орлогын хувийн жин өссөн буурсан хэлбэлзэлтэй байгаа нь БЗС-ийн санхүүжилт тайлант хугацаандаа ороогүй он дамжин хийгдсэнтэй холбоотой. 2020 оны төсвийн санхүүжилтийн хувь хэмжээ буурснаар зөвхөн өөрийн үйлчилгээний орлого (96.8 хувь)-оор эх үүсвэрээ бүрдүүлжээ.

Өөрийн үйл ажиллагааны орлогын дүнд сургалтын төлбөрийн оролцоо 2019 онд 65.7 хувь, 2020 онд 79.1 хувь болж өссөн, 2021 онд 73.1 хувь болж буурсан байна. Бүхэлд нь дүгнэвэл үйл ажиллагааны өөрийн санхүүжилт /дан ганц сургалтын төлбөрөөс хамааралтай/ сургалтын

төлбөрөөс бусад орлого буурч, тус орлогын оролцоо нь суларсаар байна. Үндсэн ажиллагааны мөнгөн орлого өсөхийн хэрээр мөнгөн зарцуулалт нь 2019-2021 онд 5,072.5 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар 2020-2021 онд 8,598.0 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар нэмэгдсний зэрэгцээ мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг мөн 2019-2021 онд 5,973.3 сая төгрөг буюу 15.0 хувиар, 2020-2021 онд 5,779.5 сая төгрөг буюу 14.4 хувиар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 13. МУИС-ийн нэгдсэн мөнгөн орлогод эзлэх зарлагын хувийн жин, өөрчлөлт

Мөнгөний урсгал	Хувийн жин			Өөрчлөлт			
	2019	2020	2021	2019 - 2020		2020- 2021	
				сая.төг	хувиар	сая.төг	хувиар
1.Үндсэн ажиллагааны урсгал зарлага	79.5	93.1	80.1	2,409.7	5.21	5,357.7	12.4
2.Хөрөнгө оруулалтын зарлага	6.2	6.6	9.5	2,662.8	73.1	3,240.3	105.7
Мөнгөн хөрөнгийн өсөлт	14.3	0.3	10.4	5,973.3	15.0	5,779.5	14.4

Зарлагын үндсэн бүтцээр харуулбал үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал өссөн, буурсан хөрөнгө оруулалтын хувьд өссөн үзүүлэлттэй байна. Харин 2020 онд нийт орлогынхоо 93.1 хувийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал зардалд, 6.6 хувийг хөрөнгө оруулалтын зарлагад зарцуулснаар (БОҮТ-ийн барилгын ажлыг эхлүүлсэн) мөнгөн хөрөнгийн хуримтлал буурсан бол 2021 оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж хуримтлал бий болжээ. МУИС-ийн нийт мөнгөн зарлагыг бүтцээр болон нэр төрлөөр нь зэрэгцүүлэн тооцвол:

Хүснэгт 14. МУИС-ийн үндсэн ажиллагааны нэгдсэн мөнгөн зарцуулалтын бүтэц, бүрэлдэхүүн

Зарцуулалтын бүрэлдэхүүн	Хувийн жин			Өөрчлөлт /2019-2021/		
	2019	2020	2021	сая.төг	х/жин	хувиар
1. Ажиллагчидтай холбоотой зардал	61.1	66.8	62.7	3,998.60	8.7	165.9
2. Ашиглалтын тогтмол зардал	2.3	2.1	1.7	-198.3	-0.4	-8.2
3. Бараа үйлчилгээ, бүгд. Үүнээс:	29.4	24.5	24.1	-1,387.50	-3.0	-57.6
3.1 Хичээл сургалтын дадлага	4.9	2.3	4	-225.3	-0.5	-9.3
3.2. Эрдэм шинжилгээ	12.9	9.7	9.1	-1,441.20	-3.1	-59.8
3.3. Урсгал засвар	1.5	2.8	2.6	666.2	1.4	27.6
3.4. Багшийг дэмжих	1.5	1.4	1.2	-136.3	-0.3	-5.7
3.5. Оюутны үйлчилгээ	2.1	1.6	1.8	-52.1	-0.1	-2.2
3.6. Харуул хамгаалалт	0.7	0.8	0.7	26.1	0.1	1.1
3.7. Гадаад томилолт, зочны	1.4	0.2	0.4	-466.4	-1.0	-19.4
3.8 . Төлбөр хураамж	1.5	1.1	1.3	-28.2	-0.1	-1.2
3.9. Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1.1	1.5	1	6.5	0.01	0.3
3.10 Хангамжийн материал, бусад	2.3	3.1	2.1	263.1	0.6	10.9
Үндсэн ажиллагааны мөнгөн зарцуулалтын дүн	92.7	93.4	88.5	2,409.70	5.2	100.0
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	7.3	6.6	11.5	2,662.80	73.1	100.0

МУИС-ийн 2019-2021 онуудад санхүүгийн нэгдсэн тайлангийн үйл ажиллагааны мөнгөн зарцуулалтын дундажаар 63.5 хувийг ажиллагчдын цалин шимтгэл, 2.0 хувийг ашиглалтын тогтмол зардал, 26.0 хувийг бараа үйлчилгээ, хангамжийн мөнгөн зарцуулалт тус бүр эзэлж байна. Үндсэн үйл ажиллагааны ажиллагчидтай холбоотой зардлаас бусад мөнгөн зарцуулалт 1,585.8 сая төгрөг буюу 3.43 пунктээр буурсны 8.2 хувийг ашиглалтын тогтмол зардал, 56.6

хувийг бараа үйлчилгээ зардал (тэр дундаа эрдэм шинжилгээ төсөл арга хэмжээ 59.8 хувь, гадаад томилолт 19.4 хувь, хичээл сургалт дадлага 9.3 хувь, багшийг дэмжих 5.7 хувь, оюутны үйлчилгээ 2.2 хувь) эзэлж байна. Харин эсрэгээр хөрөнгө оруулалтын зарцуулалт нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтаас бусад зарцуулалт буурсан нь хичээл сургалт танхим, цахим гэсэн хэлбэрээр явуулсантай холбоотой мөн олон нийтийн зарим хөтөлбөр арга хэмжээг түр хойшлуулсан нөлөөлөл байна.

Эндээс бүхэлд нь дүгнэвэл 2019-2021 онд сургалтын үйлчилгээ хангамжийн, тэр дундаа хичээл сургалтын дадлагын зардал болон эрдэм шинжилгээ, оюутны үйлчилгээний зарцуулалт өсөлт, бууралт, өсөлттэй, тэдгээрийн хувийн жингийн ялгаатай байдал нь цар тахал, ковид-19-тэй хамаарал нөлөө байна. Хэдийгээр цар тахлын үе таарсан ч багш оюутны үйлчилгээний төвийн барилгын ажлаа эхлүүлэн 50 гаруй хувийн гүйцэтгэлтэй байгаа нь сайшаалтай. Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайлангийн шинжилгээнүүд нь санхүүгийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах, илүү тодорхой, бодитой үр дүн, арга замыг илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зорилготой учраас бүрэлдэхүүний болон салбар сургууль, нэгж бүрээр шинжилгээг жил бүр хийж байх нь хэрэгтэй.

Дөрөв. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зэрэгцүүлэлт

Бүрэлдэхүүний сургуулиудын 2021 оны урсгал зарлагын төсвийн гүйцэтгэл-Бүрэлдэхүүний сургуулийн 2021 оны нийт урсгал зардлыг батлагдсан төсөвтэй харьцуулбал 3,148.05 сая төгрөг буюу 8.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Буурсан дүнгийн 19.35 хувь төсвийн 1.70 пунктийг цалин хөлсний зардал, 22.66 хувь буюу төсвийн 1.99 пунктийг бараа үйлчилгээний зардал, 30.37 хувь буюу төсвийн 2.67 пунктийг сургалтын үйлчилгээний зардал, 1.51 хувь буюу төсвийн 0.13 пунктийг оюутны үйлчилгээний зардал, 23.68 хувь буюу төсвийн 2.08 пунктийг эрдэм шинжилгээний зардал, 2.42 хувь буюу төсвийн 0.21 пунктийг тогтмол зардал бүрдүүлсэн байна.

ШУС-ын урсгал зардлын хэтрэлт-Төлбөр хураамжийн зардал 64.8 сая төгрөг, эрдэм шинжилгээ, инновацийн зардал 11.5 сая төгрөг, оюутны тэтгэлэг 34.2 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Төлбөр хураамжид шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлд 57.2 сая төгрөг (төсөвт тусгаагүй), хичээл практикийн хөтөлбөр арга хэмжээний зардал (магадлангийн зардал)-ыг тус ангиллаас зарцуулсан нь, оюутны тэтгэлэгийн зардалд БНСУ-ын Солонгос сангийн 34.2 сая төгрөгийн тэтгэлэгийг төсөвт тусгаагүй зэргээс тус тус хэтрэлт бий болсон бол эрдэм шинжилгээний зардлаа төсөвлөхдөө эдийн засгийн ангилалаа буруу төсөвлөснөөс тус зардал 11.5 сая төгрөгөөр хэтэрч бодлогын судалгааны зардал нь 83.1 сая төгрөгөөр хэмнэлтийг бий болгожээ. ШУС нь хичээл практикийн зардалд 30 хөтөлбөр магадлан итгэмжлүүлэхээр төлөвлөснөөс 20 хөтөлбөрийн магадлан итгэмжлүүлэх ажил хийгдээгүй тул 155.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ. Салбар хоорондын тооцоо нь төсөвлөсөн сууриараа хэрэгжиж гүйцэтгэл хийгдээгүй байна. Цаашид салбар хоорондын тооцоог зөв байршуулан зөв тайлагнах нь явдал нь чухал байна.

ХШУИС-ийн урсгал зардлын хэтрэлт-Цалингийн зардал 18.8 сая төгрөгөөр (үндсэн цалин, НДШ төсөвлөсөн дүнгээс 161.5 сая төгрөгөөр хэмнэлт, илүү цаг цалин 100.2 сая төгрөгөөр, цагийн хөлс 77.8 сая төгрөгөөр хэтрэлт), дадлага болон хичээлийн материалын зардал 46.9 сая төгрөгөөр тус тус хэтэрчээ. Цалин хөлсний зардал хэмнэгдэхэд түр чөлөөтэй байгаа орон тооны өөрчлөлт нөлөөлсөн хэдий ч цагийн хөлс, илүү цагийн гүйцэтгэл хэт өндөр өөрчлөлттэй байгаа нь цаашид багшийн ногдлын гүйцэтгэлд дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй. Мөн хичээл практикийн зардал нийт дүнгээрээ хэтрээгүй ч зарим төлөвлөсөн ажил хийгдээгүй ч бусад зардлыг хэтрүүлэн зарцуулж байгаа нь төсвийн сахилга бат, төсөв хийх үеийн хариуцлага сул байгааг илтгэж байна. Хэт үрэлгэн хандлагатай байна.

ХЗС-ийн хэтрэлт хэмнэлт-Хэвлэл сурталчилгааны зардал 465.0 мянган төгрөгөөр, ЭШИ-ийн зардал 20.9 сая төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлогын татвар 8.7 сая төгрөгөөр хэтэрсэн. Цалин хөлсний зардал нийт дүнгээрээ 203.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн 5 багш чөлөө авсантай холбоотой гадна цагийн хөлсний хэмнэлт үүссэн байна. Эрдэм шинжилгээний зардлын хэтрэлт нь дотоодын байгууллагын төсөл хөтөлбөр хэрэгжсэн ба (төсөвт тусгаагүй) тухайн үед шийдвэр гараагүй, тодорхойгүй байсантай холбоотой өссөн, хадгаламжийн хүүгийн орлого төсөвлөсөн хэмжээнээс давсны улмаас хүүгийн татвар өссөн байна.

ОУХНУС-ийн хэтрэлт хэмнэлт-Цалин,НДШ-ийн зардал 44.9 сая төгрөг, ЭШИ-ийн дотоод эх үүсвэрээр санхүүжигдсэн зардал 14.0 сая төгрөгөөр, гадаад эх үүсвэрээр санхүүжигдсэн дүн 7.0 сая төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 4.5 сая төгрөгөөр хэтрэлтийг бий болгожээ.

Цалин хөлсний зардлын хэтрэлт нь санхүүгийн жилийн дундуур албан тушаалын бүтэцэд өөрчлөлт орсноос, харуул хамгаалалтын зардал нь гэрээний дүнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт орсноос, ЭШИ гадаад эх үүсвэр төсөл (10.0 сая төгрөг гэж төсөвлөснөөс 18.5 сая төгрөг болж) давж орж ирснээс тус тус хэтэрч, харин ЭШИ-ийн дотоод эх үүсвэрийн зардлын эдийн засгийн ангиллыг буруу төсөвлөснөөс хэтрэлт үүссэн байна.

БС-ийн хэтрэлт хэмнэлт-Цалин, НДШ-ийн зардал 29.8 сая төгрөгөөр, тэтгэмж 9.4 сая төгрөгөөр, тэтгэвэр 7.3 сая төгрөгөөр, эрдэм шинжилгээний зардал 117.5 сая төгрөгөөр тус тус хэтэрчээ. Хичээл практикийн зардал нь нийт дүнгээрээ хэтрээгүй ч төсвөөс зориулалтын бус зарцуулалт их байна. Тухайлбал тус ангиллаас цай кофе, бэлэг дурсгал, тавилга эд хогшил, цалин урамшуулал, номны гаалийн татвар гэх мэт.⁸

Бүрэлдэхүүний сургуулиудын хэмнэлтийн шалтгаан үндэслэл-Цар тахлын улмаас хорио цээртэй холбоотой цахимаар сургалт явагдаж олон нийтийг хамарсан арга хэмжээний зардлууд нь зарцуулагдаагүй байна.

Бусад хүрээлэн төв болон бие даасан нэгжийн хэтрэлт хэмнэлт- МЯТ-ийн үйл ажиллагааны цикл нь сургуулийн үйл ажиллагаатай зөрүүтэй байдал нь төсвийн үйл явцад нөлөөлж батлагдсан төсвөөсөө гүйцэтгэл зөрүүтэй гарах нөхцөл шалтгаан болж байна. ЭШИ-ийн төсвийн төлбөр хураамж 54.5 сая төгрөгөөр, эрдэм шинжилгээний зардал 55.3 сая төгрөгөөр, хөрөнгө нь 40.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь гадны төсөл хөтөлбөр эх үүсвэр (1.1 тэрбум төгрөг)-өөр нэмэгдсэнтэй холбоотой. Хэдийгээр гадны эх үүсвэртэй ч төсөл хөтөлбөрийг бүртгэлжүүлж аль болох бүрэн төлөвлөгөөнд тусгах ажлыг хийх нь хэт их зөрүү үүсгэхгүй байх явдал юм.

Бүрэлдэхүүний сургуулиудын 2021 оны хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэл-бүрэлдэхүүний сургуулийн нийт хөрөнгө төсөвлөсөн дүнгээс 770.3 сая төгрөг буюу 39.1 хувиар буурчээ. Үүний барилгын хөрөнгө оруулалт 217.4 сая төгрөгөөр буурсны 134.0 сая төгрөг ХЗС-ийн, 83.2 сая төгрөг нь БС-ийн хөрөнгө оруулалттай холбоотой байна. СТТ-ийн хөрөнгийг зардлыг ХЗС 6.5 сая төгрөгөөр, БС 2.6 сая төгрөгөөр, ХШУИС биет хөрөнгийн зардлыг 23.7 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн худалдан авалт хийсэн. Сургалтын тоног төхөөрөмж бүгд 256.8 сая төгрөг, тавилга эд хогшил бүгд 260.1 сая төгрөг, ном сурах бичиг бүгд 47.7 сая төгрөгөөр төсөвлөсөн дүнгээс буурсан байна. Үүнээс сургалтын тоног төхөөрөмжийн 219.9 сая төгрөг (ШУС 103.3 сая төгрөг, ХШУИС 116.6 сая төгрөг)-ийн 160.2 сая төгрөгийн нийлүүлэлт он дамжихаар болжээ.

Бүрэлдэхүүний сургуулийн төсвийн гүйцэтгэлийн тайлагналтийг бүхэлд нь дүгнэвэл орлого зарлагын эдийн засгийн ангилалыг бодитой төлөвлөгөөгүй, зарим төсвийг хэт хөөсрүүлэн төсөвлөх, төсвийг зориулалтын бус зарцуулах, зардал хэтрүүлэх, эдийн засгийн ангилал шилжүүлэх, дотоод тооцооны төсөв, гүйцэтгэлийг буруу байршуулан тайлагнах зэргээр төсөвлөлт, тайлагналт хангалтгүй байгааг илтгэж байна.

Төсвийн нэгжээр болон эдийн засгийн ангилал бүрээр гүйцэтгэлийг харахад төсвийн хэтрэлттэй байдлууд олон байна. Хэдийгээр үндсэн үйл ажиллагаа цар тахлын нөлөөгөөр танхимаас цахимт шилжин хэмнэлттэй ажилласан ч нөгө талаас зардлыг хэт хөөсрүүлэн төлөвлөх, үндэслэл, тооцоо судалгаа муутай боловсруулсан байдал нь төсөвт хэмнэлт үүсэхэд нөлөөлсөн байх үндэслэлтэй. Мөн гүйцэтгэлийг төсөвлөсөн сууриар бүртгээгүй зэрэг

⁸ Бизнесийн сургуулийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн задаргаа.

нэгжүүдийн хариуцлага, ур чадвартай холбоотой дутагдлууд их байгаа нь төсвийн сахилга бат сул байна гэж дүгнэхээр байна.

Хүснэгт 25. Нийт урсгал болон хөрөнгийн зардлын хооронд шилжүүлсэн дүнд бүрэлдэхүүний сургууль, нэгжийн зөрүүний эзлэх хувь.

БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГУУЛЬ, НЭГЖ	Хувийн жин			Тайлбар
	2019	2020	2021	
1. ШУС	34.22	59.00	65.00	
2. ХШУИС	11.90		34.00	
3. ХЗС	0.52			
4. БС	5.51			
5. ТӨВ.САН	12.94	41.00		
6. МСХ	25.94		1.00	
7. МЯТ	8.43			
8. ЦСТ	0.45			
Дүн	100.0	100.0	100.0	

Цаашид дээр асуудлуудыг анхааран төсөв болон төсвийн гүйцэтгэлийн суурийг ижил болгох, төсөв төлөвлөх, батлуулах, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах тал дээр бүрэлдэхүүний сургууль, нэгжүүд хариуцлагатай хандаж байх, төсвийн гүйцэтгэлийг дэлгэрэнгүй задаргаатай гаргах бүртгэлийг сайжруулах, холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллах, зарим дүрэм журмуудыг шинэчлэн боловсруулах /санхүүгийн журам/, бүртгэлийн бодлогын баримт бичгүүдэд төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргах зааврыг нарийвчлан тодорхой тусгах, явцын дотоод хяналтыг сайжруулах, бүрэлдэхүүний болон салбар сургууль нэгжээр төсвийг тайлагнах ажлыг зохион байгуулах, төсөвлөлтийг үр дүнд суурилсан стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх явдал юм.

Захиргаа, төвлөрсөн сангийн төсвийн гүйцэтгэл - Нийт үндсэн 14 газар, хэлтэс, төв, номын сангаас гадна захиргааны шийдвэрээр оюутны байрыг, ЦСБТ-ийн тайланг хамрууллаа. Захиргаа, төвлөрсөн сангийн 2021 оны нийт урсгал зардал батлагдсан төсөвтэй харьцуулбал 1,103.25 сая төгрөг буюу 10.53 хувиар буурсан, 2019 онтой харьцуулахад 324.7 сая төгрөгөөр, 2020 онтой харьцуулахад 1,507.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Эрдэм шинжилгээний зардал 706.1 сая төгрөг буюу 64.0 хувийг, сургалтын үйлчилгээний зардал 309.3 сая төгрөг буюу 28.0 хувиар буурсан нь энэхүү урсгал зардлын хэмнэлтийн нилээд хэсгийг тайлбарлаж байна.

Эрдэм шинжилгээний зардал - судалгааны журмаар олгодог санхүүжилтийг бүрэлдэхүүний сургуулиад дотоод тооцоогоор шилжүүлэн тус сургуулийн гүйцэтгэлээр тайлагнасан нь зарцуулаагүй мэт харагдаж байгаа ч МУИС-ийн нийт дүнгээр энэхүү зардал нь зориулалтын дагуу зарцуулагдсан болохыг нэгтгэсэн тайлан болон Хавсралт ...-аас харж болно.

Сургалтын үйлчилгээний зардал - Энэхүү зардал цар тахалтай холбоотой төлөвлөгдсөн арга хэмжээнүүд хойшлогдсноос нийт төсвийн хэмнэлтийн 28.04 хувийг бүрдүүлж байгаагаас хичээл практикийн зардал дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Оюутны үйлчилгээний зардал - Нийт 1.0 тэрбум төгрөг төсөвлөснөөс 854.0 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж 153.4 сая төгрөгөөр буурсан байна. Нийт 796 оюутанд 709.9 саятөгрөгийн тэтгэлэг олгосноос дотоод эх үүсвэрээс 596.01 сая төгрөгийг, ЗГ хоорондын гэрээнээс 55.3 сая төгрөгийг, бусад эх үүсвэрээс 55.3 сая төгрөгийг санхүүжүүлжээ. Дэлгэрэнгүйг Хавсралт ...-аас үзнэ үү. Оюутан, төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийн арга 36-н нэр төрлийн үйл ажиллагаа арга хэмжээнд 196.6 сая төгрөг төсөвлөснөөс 144.1 төгрөг зарцуулж 119.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон нь цар тахалтай холбоотой олон нийтийн үйл

ажиллагаа хойшлогдсонтой холбоотой. /нэгжийн тайлан ирээгүй тул арга хэмжээ бүрээр дүгнэх болмжгүй байна./

Дотоод тооцоо - Дотоод тооцоо нь төсөвлөсөн дүнгээс 832.4 сая төгрөөр давсан үүний 65.1 хувийг судалгааны дотоод санхүүжилт, үлдсэн хувийг сурах бичиг болон бусад санхүүжилт бүрдүүлжээ. Судалгааны санхүүжилтийн хувьд МУИС-ийн бодлогоор судалгааны журмын дагуу хийгддэг санхүүжилт хэдий ч гүйцэтгэлийг төсөвлөсөн сууриас гаргаагүй нь зарцуулаагүй мэт харагдаж байна. Төсвийн гүйцэтгэл төсөвлөсөн сууриар хийгдээгүй нь тохируулгын тайланг гаргахгүй байгаатай холбоотой бөгөөд цаашид энэ асуудлыг хэрхэн хаана төсөвлөж хаана зардлыг хүлээж зөвшөөрөх зэрэг төсвийн байршлыг холбогдох журам болон бодлогын баримт бичигт тусгах нь зүйтэй.

Бараа үйлчилгээний зардал -Бараа үйлчилгээний зардал нь 121.3 сая төгрөгөөр хэтэрсний дийлэнх хувийг урсгал засварын зардлын хэтрэлт (нийт 44.71хувь)-ийг бүрдүүлж байна. Энэ их засвараар төсөвлөсөн засварын гүйцэтгэлийг урсгал засварт оруулж тайлагнасан байна. Цар тахалтай холбоотой хичээлийн болон оюутны байрны ариутгал халдваргүйжүүлэлт, эм хангамжтай холбоотой АА-н зардал төсөвлөсөн дүнгээс 23.5 сая төгрөгөөр хэтэрчээ. Ахмадын сан, интернэт, харуул хамгаалалт гэх мэт зардлыг төсөвлөсөн сууриар бүртгэж тайлагнаагүйгээс төв сангийн зардал хэтэрсэн харагдаж байна.

Хөрөнгийн зардал - Хөрөнгийн зардал төсвөөс бүгд дүнгээрээ 6,662.1 сая төгрөг буюу 60.08 хувиар буурчээ. Үүний 6.2 тэрбум төгрөг буюу 93 хувийг барилгын хөрөнгө оруулалт, их засвар 448.84 сая төгрөг буюу 6.7 хувийг их засвар, үлдсэн 236.96 сая төгрөг буюу 3.56 хувийг ТЭХ, ном сурах, биет бус хөрөнгө бүрдүүлж харин сургалтын тоног төхөөрөмж 220.0 сая төгрөг буюу төсөвлөсөн дүнгээс 56.3 хувиар давсан (хэтэрсэн) байна. Хөрөнгийн хэмнэлтийг дүгнэвэл төлөвлөсөн хөрөнгө оруулалтаас БОУТ-ийн ажлын үлдэгдэл санхүүжилт 3.7 тэрбум төгрөг, хичээлийн 7 дугаар байр хөрөнгө оруулалтын 2.4 тэрбум төгрөг зарцуулагдаагүй хойшлогдсон байна. Их засварыг төсөвлөсөн суурийн дагуу тайлагнаагүй, тавилга эд хогшлын худалдан авалт 10.6 сая төгрөг (төсөвлөсөн дүнгийн 28.0 хувь)-ийн сонгон шалгаруулалт амжилттай болж нийлүүлэлт хийгдсэн ба төлөвлөсөн дүнгээс 2.9 сая төгрөгөөр давсан, СТТ худалдан авалт 220.0 сая төгрөг буюу 56.3 хувиар хэтэрсэн (төсөвт тусгагдаагүй худалдан авалт) байна. Биет бус хөрөнгийн 131.8 сая төгрөг үлдэгдлийн 31.0 сая төгрөг нь санхүүгийн системийн хэмнэлт, бусад нь гэрээний үлдэгдэл санхүүжилт байна. *Дэлгэрэнгүйг Хавсралт ...-ээс үзэх.* Тухайлбал: МТГ нь 100.9 сая төгрөгийн төсөв өртгөөр 277.0 төгрөгийн худалдан авалт хийх, ОБ-4 байрны их засвар төсөвт өртөг (488.84 сая төгрөг)-өөс 279.0 сая төгрөгөөр хэтрүүлэн гэрээлснээс гадна хэд хэдэн нэгж төсөвгүй худалдан авалт хийсэн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг УЗ-өөс баталсан тогтоолын дагуу төсвийн нэгжээр багцлаагүй хөрөнгийн төрлөөр багцалсан нь эмх цэгцгүй байдлыг бий болгож төсвийн хэрэгжилтийг (төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг нарийвчлан дүн шинжилгээ хийх) хянах боломжгүй байна. Цаашилбал энэ нь төсвийн сахилга батыг сулруулах, төсвийн зориулалтыг өөрчлөн ашиглах, төсөвт өртгийг нэмэгдүүлэх, дараа оны хөрөнгийн төсвийн төсөөллийг боловсруулахад сөрөг үр нөлөөтэй байна. Иймээс төлөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг ТЭЗҮ хийгдээгүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг төсөвт тусгахгүй байх, батлуулахгүй байх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд гаргаж байх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний багцыг баталсан төсвийн дагуу хийх явдал юм.

Хүснэгт 27. Захиргаа, төвлөрсөн сангийн төсвийн гүйцэтгэл

Зарлагын бүрэлдэхүүн	2019		2020		2021		Өөрчлөлт /2021/		
	төсөв	Гүйц	Төсөв	гүйц	төсөв	гүйц	сая.төг	х/жин	хувиар
1. УРСГАЛ ЗАРДАЛ	10,448.36	9,023.01	10,412.04	7,867.26	10,478.15	9,374.70	1,103.25	10.53	100.00
1.Цалин хөлсний зардал	5,107.56	4,880.61	5,203.44	4,773.86	5,387.65	5,239.00	148.65	2.76	13.47
1.1 Үндсэн цалин	4,123.95	3,971.95	4,413.33	4,115.02	4,484.70	4,361.99	122.71	1.17	11.12
1.2 Цагийн хөлс	88.00	70.96	140.07	137.88	31.00	59.34	-28.34	-0.27	-2.57
1.3 Илүү цагийн хөлс	121.90	83.51	65.30	59.46	59.09	59.67	-0.58	-0.01	-0.05
1.4 Урамшуулал	206.20	210.35	230.00	201.34	214.23	212.92	1.31	0.01	0.12
1.5 НДШ	567.51	543.84	354.74	260.16	598.63	545.08	53.55	0.51	4.85
1.2.Бараа үйлчилгээний нийтлэг зардал	1,831.30	1,417.20	1,869.30	1,408.40	1,908.30	2,029.60	-121.30	-6.36	-10.99
1.2.1 Бичиг хэрэг	76.40	32.90	44.50	38.40	66.10	15.80	50.30	0.48	4.56
1.2.2 Аж ахуйн зардал	180.00	135.50	268.60	361.40	357.50	381.00	-23.50	-0.22	-2.13
1.2.3 Шуудан холбооны зардал	12.50	13.10	12.20	8.50	23.60	24.90	-1.30	-0.01	-0.12
1.2.4 Шатахуун, сэлбэгийн зардал	44.00	32.40	42.70	28.00	44.70	20.00	24.70	0.24	2.24
1.2.5 Албан томилолтын зардал	24.40	11.60	8.00	3.20	8.70	13.20	-4.50	-0.04	-0.41
1.2.6 Шагналын зардал	15.30	13.10	15.00	13.90	16.00	23.00	-7.00	-0.07	-0.63
1.2.7 Хамт олонд зориулсан арга хэмжээ	28.00	55.70	29.70	10.50	30.50	10.80	19.70	0.19	1.79
1.2.8 Ахмадын сан	17.10	83.00	16.70	27.60	44.60	69.60	-25.00	-0.24	-2.27
1.2.9 Гадаад харилцаа, ХА-ны зардал	479.50	376.70	194.00	54.40	196.80	116.80	80.00	0.76	7.25
1.2.10 Тусламж, тэтгэлэгийн зардал	10.00	19.10	13.00	29.50	25.00	24.80	0.20	0.00	0.02
1.2.11 Тэтгэвэр тэтгэмжийн зардал	86.90	67.10	151.40	90.20	80.00	92.80	-12.80	-0.12	-1.16
1.2.12 Урсгал засварын зардал	456.60	277.90	476.40	446.10	423.20	916.50	-493.30	-4.71	-44.71
1.2.13 Төлбөр хураамжийн зардал	332.10	254.70	543.10	253.80	529.80	299.80	230.00	2.20	20.85
1.2.14 Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны зардал	68.50	44.40	54.00	42.90	61.80	20.60	41.20	0.39	3.73
1.3.Сургалтын үйлчилгээний зардал	1,282.80	866.70	874.00	425.20	768.20	458.70	309.30	40.26	28.04
1.3.1 Тогтмол хэвлэлийн зардал	13.30	15.40	5.90	7.40	6.50	5.80	0.70	0.01	0.06
1.3.2 Хичээл практикийн зардал	1,066.10	508.90	642.60	237.30	603.90	290.20	313.70	2.99	28.43
1.3.3 Интернэтийн зардал	46.50	212.80	53.30	39.00	45.00	68.20	-23.20	-0.22	-2.10
1.3.4 Уралдаан тэмцээний зардал	27.90	26.00	42.80	21.30	18.30	11.00	7.30	0.07	0.66
1.3.5 Гадаад багшийн зардал	13.80	-	10.00	-	-	-	0.00	0.00	0.00
1.3.6 БАҮАДЗ	115.20	103.60	119.40	120.30	94.30	83.50	10.80	0.10	0.98
1.4.Оюутны үйлчилгээний зардал	983.60	745.10	925.70	640.40	1,007.40	854.00	153.40	15.23	13.90
1.4.1 Оюутны ү/а-г дэмжих	329.80	225.00	242.40	101.10	263.90	144.10	119.80	1.14	10.86
1.4.2 Оюутны тэтгэлэг	653.80	520.10	683.30	539.30	743.50	709.90	33.60	0.32	3.05
1.5.Эрдэм шинжилгээний зардал	784.90	390.30	1,034.30	226.30	901.30	195.20	706.10	78.34	64.00
1.5.1 ЭШ, инновацийн зардал	385.00	343.00	92.00	211.50	338.60	195.20	143.40	1.37	13.00
1.5.2 ЭШ төсөл бусад эх үүсвэрээс	294.00	25.50	525.50	-	30.00	-	30.00	0.29	2.72
1.5.3 Судалгааны суурь зардал	1.00	0.20	2.00	-	11.00	-	11.00	0.10	1.00
1.5.4 Ассистантшип	6.00	4.60	19.20	10.80	37.70	-	37.70	0.36	3.42
1.5.5 АТСБГ-ын зардал	30.00	17.10	295.30	4.00	-	-	0.00	0.00	0.00
1.5.6 Өндөр түвшний судалгаа, МС	68.00	-	90.00	-	260.00	-	260.00	2.48	23.57
1.5.7 Залуу судлаачийн багийн тэтгэлэг	-	-	0.30	-	80.00	-	80.00	0.76	7.25
1.5.8 Зочин судлаачдын грант	0.90	-	10.00	-	144.00	-	144.00	1.37	13.05
1.6.Тогтмол зардал	458.20	723.10	505.30	393.10	505.30	598.20	-92.90	-18.39	-8.42
1.6.1 Гэрэл цахилгааны	220.00	227.50	210.00	158.60	210.00	194.70	15.30	0.15	1.39
1.6.2 Халаалтын	112.00	120.00	135.00	92.90	135.00	178.00	-43.00	-0.41	-3.90
1.6.3 Цэвэр бохир усны	35.20	68.80	55.00	46.30	55.00	54.80	0.20	0.00	0.02
1.6.4 Харуул хамгаалалтын	91.00	306.70	105.30	95.30	105.30	170.70	-65.40	-0.62	-5.93
2. ДОТООД ТООЦООНЫ ШИЛЖҮҮЛЭГ	1,272.12	1,534.20	285.37	1,559.10	632.81	1,465.20	-832.39	-56.81	100.00
2.1 Сурах бичгийн санхүүжилт	126.65	62.20	-	111.10	0.00	1.80	-1.80	-0.12	0.22
2.2 Судалгааны санхүүжилт	1,135.47	912.60	-	928.20	0.00	542.10	-542.10	-37.00	65.13
2.3 Бусад зардлын санхүүжилт	10.00	559.40	285.37	519.80	632.81	921.30	-288.49	-19.69	34.66
3. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,226.80	1,223.40	14,395.10	864.90	11,014.77	4,352.69	6,662.08	60.48	100.00
3.1 Барилгын хөрөнгө оруулалт	12,320.00	289.10	11,873.50	155.80	9,658.53	3,462.24	6,196.29	56.25	93.01
3.2 Их засварын зардал	49.40	51.20	740.00	-	448.84	-	448.84	4.07	6.74
3.3 СТТ ху/авах зардал	547.90	382.00	974.10	327.50	390.58	610.59	-220.01	-2.00	-3.30
3.4 ТЭХ ху/авах зардал	194.50	18.40	180.60	132.90	37.92	10.64	27.28	0.25	0.41
3.5 Ном сурах бичиг ху/авах	341.00	92.70	277.80	130.80	178.90	101.02	77.88	0.71	1.17
3.6 Тээврийн хэрэгсэл ху/авах	390.00	390.00	-	-	-	-	0.00	0.00	0.00
3.7 Биет бус хөрөнгө ху/авах	384.00	-	349.10	117.90	300.00	168.20	131.80	1.23	1.98

Захиргаа төвлөрсөн сангийн эх үүсвэр - Захиргаа төвлөрсөн сангийн санхүүгийн эх үүсвэрийн өөрийн үйл ажиллагааны орлого нь 7.5-8.8 орчим хувь, бусад эх үүсвэр нь дотоод тооцооны санхүүжилт болох төвлөрүүлэлт, өмнөх оны хуримтлагдсан мөнгөн хөрөнгөөс бүрдэж байна. Тухайн жилийн зарцуулагдаагүй мөнгөний үлдэгдэл дараа оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл болон дараа онууддаа дахин хуваарилагдан төлөвлөгдөж байна.

Хүснэгт 27. Захиргаа, төвлөрсөн сангийн эх үүсвэрийн бүрдэлт, бүрэлдэхүүн (сая төгрөгөөр)

Зарлагын бүрэлдэхүүн	2019 он		2020 он		2021 он		Гүйцэтгэлийн өөрчлөлт 2020/2021		
	төсөв	Гүйц	төсөв	гүйц	Төсөв	гүйц	сая.төг	хувиар	х/жин
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	25,891.5	26,941.3	26,814.7	27,439.4	29,221.2	31,928.8	2,707.6	9.3	100.0
1.1 Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	7,102.0	7,102.0	14,885.7	14,885.7	16,610.6	17,148.0	537.4	1.8	19.8
1.2 Үндсэн үйл ажиллагааны орлого	2,257.4	2,335.5	1,644.2	2,215.8	898.0	2,378.1	1,480.1	5.1	54.7
1.2.1 Төсвийн санхүүжилт	268.0	7.7	-	0.7	-	1,100.2	1,100.2	3.8	40.6
1.2.1.1 Бодлогын дэмжлэг, ЭШ төсөл хөтөлбөр	268.0	7.2		0.7		1,100.2	1,100.2	3.8	40.6
1.2.1.2 Оюутны замын зардал		0.5							
1.2.2 Сургалтын төлбөрийн орлого	-	36.3	-	157.5	-	272.3	272.3	0.9	10.1
1.2.2.1 Бакалаврын		35.9		155.7		272.3	272.3	0.9	10.1
1.2.2.2 Магистрын		0.4		1.8			-		
1.2.3 Туслах үйл ажиллагааны орлого	1,989.4	2,291.5	1,644.2	2,057.6	898.0	1,005.6	107.6	0.4	4.0
1.2.3.1 Гэрээт ажил, ЭШ, төслийн орлого	26.0		174.0	38.7	50.0	34.4	(15.6)	(0.1)	(0.6)
1.2.3.2 Түрээсийн орлого	84.6	61.1	85.0	27.3	26.0	36.7	10.7	0.0	0.4
1.2.3.3 Хадгаламжийн хүүгийн орлого	1,300.0	1,523.8	800.0	985.7	368.0	513.5	145.5	0.5	5.4
1.2.3.4 Оюутны тэтгэлэгийн орлого	245.1	42.7	276.5	79.3	142.0	55.3	(86.7)	(0.3)	(3.2)
1.2.3.5 Хандив	55.0	35.9	10.0				-	-	-
1.2.3.6 Зуны болон түр сургалт	1.5	14.1	1.5	9.4		14.8	14.8	0.1	0.5
1.2.3.7 Диплом үнэмлэхний орлого	77.3	71.8	77.3	83.0	72.0	91.3	19.3	0.1	0.7
1.2.3.8 Хураамж, бусад	200.0	542.2	220.0	834.2	240.0	259.4	19.4	0.1	0.7
1.3 Дотоод тооцоо	16,532.1	17,503.8	10,284.8	10,337.9	11,712.6	12,402.7	690.1	2.4	25.5
1.3.1 Биеийн тамирын сургалтын орлого	742.1	1,166.9	787.6	668.8	668.8	775.9	107.1	0.4	4.0
1.3.2 Төвлөрүүлэлт /БС-аас/	15,782.8	16,002.8	9,268.9	9,268.9	11,000.0	11,000.0	-	-	-
1.3.2.1.ШУС-аас	2,425.6	2,483.8	3,418.9	3,418.9	2,417.4	2,417.4	-	-	-
1.3.2.2.ХШУИС-аас	2,106.5	2,143.2	1,200.0	1,200.0	2,249.0	2,249.0	-	-	-
1.3.2.3.ХЗС-аас	3,070.7	3,089.2	1,200.0	1,200.0	1,700.3	1,700.3	-	-	-
1.3.2.4.ОУХНУС-аас	1,392.4	1,404.5	650.0	650.0	709.5	709.5	-	-	-
1.3.2.5.БС-аас	6,787.5	6,819.9	2,800.0	2,800.0	3,923.9	3,923.9	-	-	-
1.3.3.Өвөр-Зайсан ССҮТ	7.2	4.8					-	-	-
1.3.4.БЭЛАС		16.1					-	-	-
1.3.4.Оюутны байр		41.3				563.4	563.4	1.9	20.8
1.3.5.Харуул хамгаалалт		271.9					-	-	-
1.3.5 АТС			228.3	188.3			-	-	-
1.4.6 Тогтмол зардал, бусад				212.0		45.9	45.9	0.2	1.7
1.4.7 Хэвлэлийн үйлдвэр					27.8	17.5	(10.4)	(0.0)	(0.4)
1.4.8 Хэвлэх газар					16.0		(16.0)	(0.1)	(0.6)
2.1 Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55.9	14,627.3	-	17,148.0	7,662.1	17,158.0	9,495.9	1.2	100.0

Төсвийн гүйцэтгэлийг 2019,2020,2021 оноор зэрэгцүүлбэл нийт эх үүсвэр 31.9 тэрбумд хүрч мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2019 оноос 2.4 дахин, өөрийн үйл ажиллагааны орлого нь мөн оны түвшинд, дотоод тооцоо 5.1 тэрбум төгрөг буюу 1.4 дахин нэмэгдсэн байна. Үүний үндсэн шалтгаан нь хичээлийн 7 дугаар байр болон БОҮТ-ийн барилгын хөрөнгө оруулалттай холбоотой. Захиргааны шийдвэрийн дагуу оюутны байрны мөнгөн хөрөнгө 563.4 сая

төгрөгийг дотоод тооцоогоор төв санд нэгтгэсэн байна. Сургуулийн төвлөрүүлэлт төлөвлөгөөний дагуу хийгдсэн байна. 2019-2021 оны гүйцэтгэлээр нийт орлогын дундажаар 45.0 орчим хувийг бүрэлдэхүүний 5 сургуулиас төвлөрүүлэн татжээ. Төвлөрүүлэлтээс гадна нэгжид төсөвлөгдсөн, захиргаа төвлөрсөн санд төсөвлөгдөөгүй /харуул хамгаалалт, тогтмол зардал, интернэт, ахмадын сан/ зэрэг төлбөрийг төвлөрүүлэн татсан байна.

МУИС-ийн 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгаснаар 2021 онд төсвийн санхүүжилт 15%, бусад орлого 20%-ийн хүрэхээр төлөвлөгөөнд тусгасан нь хангагдаагүй байгааг дээрх тайлан илтгэж байна. Эх үүсвэрийн хувьд эдийн засгийн ангиллыг буруу бүртгэх асуудал байна. Тухайлбал ерөнхийлөгчийн илгээлтийн төсвийн санхүүжилт 1.0 тэрбум төгрөгийг сургалтын төлбөрийн орлого ангиллаар бүртгэсэн байна. Мөн элсэгчдийн бүртгэлийн хураамжийг сургалтын төлбөрийн орлогоор бүртгэх гэх мэт.

Захиргаа төвлөрсөн сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлагналт - Захиргаа, төвлөрсөн сангийн төсөв дараах нэгжүүдээр батлагдан хэрэгждэг боловч 2019-2020 оны захиргаа, төвлөрсөн сангийн нэгжийн батлагдсан төсвийн хүрээнд хийсэн албан ёсны ажлын тайлан нь байхгүй байна. Харин 2021 оноос эхлэн www.budget.edu.mn -д нэгж бүрээр гүйцэтгэлийг сар бүр оруулж байгаа ч дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар танилцуулгын хувьд хангалтгүй байна. Захиргаа, төвлөрсөн сангийн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан хичээлийн жилээр гардаг ч санхүүгийн жилээр батлагдсан төсвийн хүрээнд тайлан хийгдсэн эсэхийг дараах зургаар харууллаа.

Зураг 6. Захиргаа, төвлөрсөн сангийн нэгжүүдийн төсвийн гүйцэтгэлээ тайлагнасан байдал

Д.д	Нэгжийн нэр	2019			2020			2021		
		Төсөв	Гүйцэтгэл	Нэгжийн тайлан	Төсөв	Гүйцэтгэл	Нэгжийн тайлан	Төсөв	Гүйцэтгэл	Нэгжийн тайлан
1	ЗХНГ	●	●	●	●	●	●	●	●	
2	ХШҮА	●	●	●	●	●	●	●	●	
3	МТГ	●	●	●	●	●	●	●	●	●
4	ЭБХ	●	●	●	●	●	●	●	●	
5	ОТХ	●	●	●	●	●	●	●	●	
6	ХЧБХ	●	●	●	●	●	●	●	●	
7	БХЦСТ	●	●	●	●	●	●	●	●	●
8	БТТ	●	●	●	●	●	●	●	●	
9	ЭШХ	●	●	●	●	●	●	●	●	
10	ИТДТ	●	●	●	●	●	●	●	●	●
11	ХАХ	●	●	●	●	●	●	●	●	
12	НС	●	●	●	●	●	●	●	●	
13	СТГ	●	●	●	●	●	●	●	●	
14	ХҮГ	●	●	●	●	●	●	●	●	●
15	ОБ	●	●	●	●	●	●	●	●	●

Эх сурвалж: ● - Бүрэн ● - Хагас ● - Огт үгүй

Захиргаа, төвлөрсөн сангийн төсвийн гүйцэтгэлийг бүхэлд нь дүгнэвэл захиргаа төвлөрсөн сангийн төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн нэгжээр нэгтгэн гаргаагүй байгаа нь захиргаа, төвлөрсөн сангийн төсвийг төсөвтэй зэрэгцүүлэн дүгнэх боломжгүй байна. Захиргаа, удирдлагын 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн санхүүжилт болон бусад орлогыг нэмэгдүүлэх тодорхой ажил хийгдээгүй, холбоотой хууль, журмын хэрэгжилт болон, зарцуулалт, тайлагналт хангалтгүй, төсвийн сахилга бат сул байна. Цаашид төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дотоод хяналтын тогтолцоог бий болгох, холбогдох хууль, эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажиллах болон төсвийн сахилга батыг сайжруулахаас гадна холбогдох бүртгэлийг сайжруулан тайлагналтыг зөв боловсруулах шаардлага байна. Төсвийн үйл явцад оролцогч талуудын чадавхийг сайжруулах, төсвийн төсөлд эрсдлийг харгалзан үзэх, төсөл арга хэмжээний өртөг, үр өгөөжийг бодитоор тооцоолон зардлын үр ашигтай байдал ба зайлшгүй эрэмбийн зарчмаар хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв байршуулан удирдах явдал юм.

Дүгнэлт

1. МУИС-ийн нийт хөрөнгийн дүн 2021 оны тайлангаар 122,193.0 сая төгрөг болж үүний 43.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 56.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө (үндсэн хөрөнгө) бүрдүүлж байгаа бол өр төлбөр ба өмчийн дүнд эзэмшигчдийн өмч 94.4 хувийг богино хугацаат өр төлбөр 5.6 хувийг эзэлж байна.
2. Өөрийн хөрөнгийн оролцоо 94.4 хувь болж тогтвортой байгаа нь бизнесийн байгууллагын хэвийн нормоос 40.0 гаруй хувиар буюу бараг 2 дахин илүү, өрийн харьцаа нь 17 дахин бага, эргэлтийн хөрөнгийн 87.2 хувийг зөвхөн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байна.
3. 2019-2021 онд томоохон хөрөнгө оруулалттай холбоотойгоор санхүүжилт өмнөх онуудаас бага тул санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын зарим үзүүлэлтүүд төлбөрийн өнөөгийн болон ойрын боломж стандарт дунджаас нилээдгүй өндөр байгаа нь санхүүгийн хувьд тогтвортой, хөрөнгө оруулалтын зориулалтаар хуримтлал бий болсон ба хуримтлагдсан нөөц хөрөнгийг оновчтой байршуулан, эргэлтэд оруулах замаар сургалт, судалгааны ажлын материаллаг баазыг шинэчлэн сайжруулах боломжтойг илэрхийлж байна.
4. Нийт үндсэн хөрөнгө 40.1 хувийн элэгдэлтэй байна. Нийт хөрөнгө оруулалтад эзлэх бусад хөрөнгө оруулалтын хувь хэмжээ жилээс жилд буурсан байгаа нь нэг талаас цар тахалтай холбоотой ч нөгөө талаас бодлогийн түвшинд сургуулийн материаллаг бааз, сургалтын орчинг сайжруулахад өөрийн хөрөнгөөс гадна бусад хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө босгох ажлыг зохион байгуулах, идэвхжүүлэх нь хэрэгтэй.
5. Төлбөртэй үйлчилгээний авлагыг бодитой бууруулж чадсан ба авлага цуглуулах хоног 2019 онд 5 хоног, 2020 онд хагас нэг сар хагас, 2021 онд сар орчим хоногоор удааширсан байна.
6. Өнгөрсөн онуудад төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийгдээгүй тул засгийн газрын оруулсан хөрөнгийн дүн тогтмол байна. Гэвч Гэгээрлийн сайдын 1999 оны Гэгээрлийн сайдын 107 дугаар тушаал “Сургалтын төлбөрийг тогтоох аргачлал”-д хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төсвөөс бүрдүүлэхээр заасан байдаг байна.
7. 2021 оны санхүүгийн нэгдсэн тайлангаар МУИС-ийн хэмжээнд нийтдээ 56,513.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнийхээ 95.4 хувийг урсгал зардалд зарцуулан орлогынхоо 4.6 хувьтай тэнцэхүйц цэвэр үр дүнтэй ажиллажээ. Санхүүгийн нэгдсэн үр дүн жил бүр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд сургалтын төлбөрийн авлага цуглуулалтын (засгийн газрын шийдвэрийн) нөлөө байна.

8. 2019 онд үндсэн бус үйл ажиллагааны үр дүн алдагдалтай гарсан тогтмол зардлын авлага (1.8 тэрбум төгрөг)-ыг үр дүн рүү хаасан нь нөлөөлсөн байна.
9. Үндсэн үйл ажиллагааны орлогын бүтцийг 2019-2021 оны дунджаар авч үзвэл 80.0 хувь нь сургалтын төлбөр, 6.9 хувь нь эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, 7.8 хувь хандив тусламж бусад (хадгаламжийн хүүгийн орлого), 4.2 хувь нь туслах үйл ажиллагааны орлого, үлдсэн 1.2 хувь нь төсвийн санхүүжилт байна. Энэ нь МУИС-ийн 2024 он хүртэлх хэрэгжүүлэхээр баталсан стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хангахгүй байна.
12. Мөнгөн урсгалын тайлангаар 2021 онд нийтдээ 60,708.2 сая төгрөгийн мөнгөн орлого орж ирсний 86.5 хувь нь өөрийн буюу үндсэн үйл ажиллагааны (үүнээс 73.1 хувь нь зөвхөн сургалтын төлбөрийн орлого) байжээ. Нийт орлогынхоо 80.1 хувийг үндсэн ажиллагаанд, 9.5 хувийг хөрөнгө оруулалт (барилга, их засвар, үндсэн хөрөнгө худалдан авах гэх мэт)-нд зарцуулж, үлдсэн хэсэг болох 10.4 хувийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг нэмэгдүүлжээ.
13. 2021 оны орлогын төсвийн гүйцэтгэлийн бүгд 60,708.2 сая төгрөг болж төсөвлөсөн дүнгээс 12,408.1 сая төгрөгөөр давсан, зарлагын төсвийн гүйцэтгэл 54,928.8 сая төгрөг болж төсөвлөсөн дүнгээс 13,690.0 сая төгрөгөөр буурчээ. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 45,816.68 сая төгрөгт хүрчээ.
14. МУИС-ийн нийт дүнгээр төсвийн орлого давсан, төсвийн хэмнэлт бий болж мөнгөн хөрөнгийн дүн өссөн боловч төсвийн нэгжүүдээр нь шинжлэхэд орлогыг боломжит хэмжээнд бүрэн төлөвлөгөөгүйгээс зарлага хэтрэх, төсвийг хэтрүүлэх, төсөвлөсөн сууриар бүртгэж тайлагнахгүй байх, зориулалтын бусаар зарцуулах зэрэг төсвийн сахилга бат муу, холбогдох хууль, журам, шийдвэрийг мөрдөж ажиллаагүй байна.
15. Нэгжүүдийн статистик тоо, мэдээ тайлангууд гарч байгаа хэдий ч хоорондын уялдаа холбоо муу, зөрүүтэй байдал харьцуулалт хийн дүгнэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.
16. 2021 оны төсвийг боловсруулахдаа МУИС-ийн стратегийн аль зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, аль KPI-г хангах нь тодорхой бус байгаа тул үр дүнг үнэлэх боломжгүй байна.
17. Төсвийн түр систем ашиглан төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланг цахимаар харах боломжийг бүрдүүлсэн хэдий ч бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн хувьд тайлагналт хангалтгүй байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- ✓ 2024 оны стратеги төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүгийн ил тод байдал, холбогдох хууль эрх зүйн хэрэгжилтийг хангах үүднээс орлого, зарлагыг боломжит хэмжээгээр бүрэн илэрхийлэх бодлого баримталж ажиллах;
- ✓ МУИС нь орлогын бүрдүүлэлтийн эрсдлийг бууруулах орлогын эх үүсвэрийн төрөл зүйлийг өргөжүүлэх, ялангуяа бүрэлдэхүүн сургуулиуд, хүрээлэн, төвүүдийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үндсэн чиглэлээ болгон ажиллах (хандив, нэрэмжит профессоршип, феллоушип, анги танхим, лаборатори, тоног төхөөрөмж, ном, тэтгэлэг, эндаумент сан зэрэг зорилтот орлогын хэмжээг нэмэгдүүлэхэд);
- ✓ НББ-ийн суурийг сайжруулах, төсөв, төсвийн гүйцэтгэлийн суурийг ижил болгож, зөв тайлагнах (төсөвлөсөн сууриараа бүртгэж тайлагнах, мөнгөн гүйлгээний тайлангийн тохируулга, ямар зохицуулалт хийхийг бодлогын бичиг баримтад тусгаж шийдвэрлэх)

- ✓ Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн тайлангийн шинжилгээнүүд нь санхүүгийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах, илүү тодорхой, бодитой үр дүн, арга замыг илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зорилготой учраас бүрэлдэхүүний болон салбар сургууль, нэгж бүрээр шинжилгээг жил бүр хийж ;
- ✓ Төлөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг ТЭЗҮ хийгдээгүй хөрөнгө оруулалтын арга хэмжээг төсөвт тусгахгүй байх, батлуулахгүй байх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуулийн хугацаанд гаргаж байх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний багцыг баталсан төсвийн дагуу баталсан төсвийн нэгжээр хийх;
- ✓ Захиргаа, төвлөрсөн сангийн нэгж бүрээр баталсан төсвийн зарцуулалтын тайлан гаргуулж дадлуулах, санхүүтэй тулгалт хийж баталгаажуулдаг байх;
- ✓ Захиргаа, төвлөрсөн сангийн гүйцэтгэлийг нэгжээр нэгтгэн боловсруулах;
- ✓ Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дотоод хяналтын тогтолцоог бий болгох, холбогдох хууль, эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажиллах болон төсвийн сахилга батыг сайжруулах;
- ✓ Хүний нөөцийн, эрдэм шинжилгээний, санхүүгийн, сургалтын системүүдийн уялдаа холбоог сайжруулах, ашиглалтыг нэмэгдүүлэх, систем хоорондын интеграци хийх боломж нөхцлийг судлах, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нэгдсэн нээлттэй өгөгдлийн сан бий болгох;
- ✓ Төсвийн үйл явцад оролцогч талуудын чадавхийг сайжруулах;
- ✓ Төсвийн төсөлд эрсдлийг харгалзан үзэх, төсөл арга хэмжээний өртөг, үр өгөөжийг бодитоор тооцоолон зардлын үр ашигтай байдал ба зайлшгүй эрэмбийн зарчмаар хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв байршуулан удирдан чиглүүлэх

